



**НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

**Улаанбаатар хот
2025**

Энэхүү судалгааг Монголын Нотариатчдын Танхимын захиалгаар Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор зарласан сонгон шалгаруулалтаар шалгарсан судалгааны баг 2025 онд гүйцэтгэсэн болно.

Судалгааны багийн бүрэлдэхүүн:

Судалгааны багийн ахлагч
Ахлах судлаач
Судлаач

Б.Өлзийсайхан, Хууль зүйн доктор (LL.D)
В.Чимгээ, Хууль зүйн магистр (LLM)
Г.Түвшинжаргал, Шинжлэх ухааны магистр (MSc)

АГУУЛГА

Нэг. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	4
Хоёр. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	6
2.1. Гэрчлэх чиг үүргийг хэрэгжүүлэгч субъект гадаадын зарим улсын гэрчлэх чиг үүрэг бүхий субъектийн харьцуулалт	6
Бүгд Найрамдах Франц Улсын нотариатын үйл ажиллагаа	11
Бүгд Найрамдах Эстони Улсын нотариатын үйл ажиллагаа	12
Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын нотариатын үйл ажиллагаа	13
Бүгд Найрамдах Сингапур Улсын нотариатын үйл ажиллагаа	14
2.3. Нотариатчдын танхимын дэргэдэх Сахилгын зөвлөлийн бүрэлдэхүүн, эрх хэмжээ, бүрэн эрхийн хугацаа	15
2.4. Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүн, эрх хэмжээ, бүрэн эрхийн хугацаа	18
2.5. Зайн гэрчлэлтийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь	22
2.6. Нотариатын мэдэгдэх хуудас, түүний ач холбогдол	27
2.7. Нотариатчид сахилгын шийтгэл оногдуулах хугацаа, сахилгын шийтгэлийн төрөл	30
2.8. Нотариатч эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаанд оролцож буй туршлага	34
Гурав. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	38
3.1. Дүгнэлт.....	38
3.2. Зөвлөмж.....	42
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	3

НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн¹ 54-т Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан бөгөөд үүнтэй холбогдуулан тус хуулийн зарим зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлага үүссэнтэй холбогдуулан Монголын Нотариатчдын Танхимаас зарласан сонгон шалгаруулалтад оролцож энэхүү үнэлгээг гүйцэтгэсэн болно.

Нотариатын тухай хууль (2011)-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Хүснэгт 1-ээр харуулав.

Хүснэгт 1. Нотариатын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт

Он	Нэмэлт оруулсан	Өөрчлөн найруулсан	Өөрчлөлт оруулсан	Хүчингүй болгосон
2011			1 хэсэгт	
2013				1 хэсгийг
2015			1 хэсэгт	
2018	3 хэсэгт		1 хэсэгт	
2019 ²	1 дүгээр зүйл (20 зүйл, хэсэг, заалт)-ээр	3 дугаар зүйл (21 зүйл, хэсэг, заалтыг)-ээр	2 дугаар зүйл (нэмсэн) 4 дүгээр зүйл (өөрчилсөн), 5 дугаар зүйл (хассан)-ээр тус тус ³	6 дугаар зүйл (8 хэсэг, 1 заалтыг)-ээр
2020	1 хэсэгт			
2021			1 хэсэгт	
2022			2 хэсэгт	
2024			1 заалтад	

Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулан 2019 онд томоохон нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна. Энэхүү хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ нь 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан зарим зүйл, хэсэг, заалтыг хамарсан болохыг дурдах нь зүйтэй.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралт VI баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу дор дурдсан үе шаттайгаар ажилласан болно.

Нэг. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. Үнэлгээ хийх шалтгаан нь Нотариатын тухай хуулийг хэрэгжүүлэх явцад Төрийн гэрчлэх чиг үүргийг хэрэгжүүлэх субъект, Нотариатын тойрог шилжих, Сахилгын болон мэргэшлийн хорооны бүрэн эрхийн хугацаа, цахим зайн гэрчлэлт, нотариатын мэдэгдэх хуудас, сахилгын шийтгэл оногдуулах хугацаа, төрөл зэрэг холбогдох зохицуулалт практикт нийцэж байгаа байдал, түүний эерэг ба сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд бэрхшээл үүсэж буй эсэх түүнчлэн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж буй энэхүү хугацаанд Эвлэрүүлэн зуучлал дахь нотариатын оролцоог хуульчлах үндэслэл шаардлагыг тодорхойлно.

¹ Монгол Улсын Засгийн газрын тогтоол, 2024., Дугаар 181.

² Монгол Улсын нотариат (Хууль тогтоомжийн эмхтгэл) Боть II, 2021., 161-167 дахь тал.

³ Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2019.5.30)

1.2. Үнэлгээ хийх хүрээг Гэрчлэх чиг үүргийг хэрэгжүүлэгч субъект, нотариатын тойрог, тойрог шилжих зохицуулалт, Сахилгын зөвлөл болон Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүн, эрх хэмжээ, бүрэн эрхийн хугацаа, цахим зайн гэрчлэлт, нотариатын мэдэгдэх хуудас, нотариатчид сахилгын шийтгэл оногдуулах хугацаа, сахилгын шийтгэлийн төрөл, нотариатч эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаанд оролцож буй гадаадын зарим улсын туршлагыг судлах гэж тодорхойлсон. Хүрээг тодорхойлсны дагуу хуулийн холбогдох зүйл, заалтыг Хүснэгт 2-д түүвэрлэн, үнэлгээ хийсэн агуулгыг тусгасан болно.

Хүснэгт 2. Үнэлгээ хийх хүрээ

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Зохицуулалтын агуулга
1	Нотариатын тухай хуулийн 4, 16 дугаар зүйл	Гэрчлэх чиг үүргийг хэрэгжүүлэгч субъект гадаадын зарим улсын гэрчлэх чиг үүрэг бүхий субъект харьцуулалт
2	Нотариатын тухай хуулийн 7 дугаар зүйл	Нотариатын тойрог, тойрог шилжих (улсын болон мужийн хэмжээнд хэрхэн шилжиж буй туршлага)
3	Нотариатын тухай хуулийн 8, дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь заалт, 51 дүгээр зүйл	Сахилгын зөвлөлийн бүрэлдэхүүн, эрх хэмжээ, бүрэн эрхийн хугацаа
4	Нотариатын тухай хуулийн 8, 15.16, 18 дугаар зүйлийн 18.1.11 дэх заалт	Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүн, эрх хэмжээ, бүрэн эрхийн хугацаа
5	Нотариатын тухай хуулийн 25 дугаар зүйл, мөн хуулийн долдугаар бүлэг, Нотариатын тодорхой үйлдэл хийх журам	Зайн гэрчлэлтийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох /гадаад улс дахь эрх зүйн орчин, Монгол Улсад нэвтрүүлэх арга зам/
6	Нотариатын тухай хуулийн 45 дугаар зүйл	Нотариатын мэдэгдэх хуудас, түүний ач холбогдол, туршлагыг судалж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал зөвлөмж боловсруулах
7	Нотариатын тухай хуулийн 51 ¹ , 54 дүгээр зүйл	Нотариатчид сахилгын шийтгэл оногдуулах хугацаа, сахилгын шийтгэлийн төрөл /сахилгын хариуцлага, эрүүгийн хариуцлага, иргэний хариуцлага, захиргааны хариуцлагын онолын харьцуулалтыг хийх, бусад хуулийн байгууллагын албан хаагчдын эрх зүйн байдлыг харьцуулан судалгаа хийж, санал зөвлөмж боловсруулах.
8	Нотариатч эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаанд оролцож буй туршлага	Гадаадын зарим улсын туршлага, ач холбогдол

1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтэд Нотариатын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд үнэлгээний хүрээг тодорхойлсон зохицуулалт зорилго, зорилтдоо хүрсэн эсэх, практикт нийцэж байгаа байдал, тухайн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэх болон бусад үр дагавар урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй ямар үр дагавар байж болохыг судлан, үнэлгээ хийх шалтгаан, үнэлгээний хамрах хүрээтэй уялдаж, бодитой хэмжиж болохуйц байдлаар томьёолсон.

1.4. Үнэлгээний харьцуулалтыг Нотариатын тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар (одоо байгаа нөхцөл байдал)-ыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хуулиар тогтоосон шаардлага, норм, хугацаа, давтамж, хэмжиж болохуйц тодорхой тоогоор илэрхийлэгдсэн тоон үзүүлэлттэй харьцуулах, үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээг гадаадын зарим улсын Нотариатын тухай хуулийн холбогдох зохицуулалттай харьцуулан дүн шинжилгээ хийсэн болно.

1.5. Нотариатын тухай хуулийн зарим зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар томъёолсон:

- ◆ Гэрчлэх чиг үүргийг хэрэгжүүлэгч субъектийн үйл ажиллагаа зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт тулгамдаж буй асуудал байгаа эсэх;
- ◆ Нотариатын тойрог, тойрог шилжих зохицуулалт зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт тулгамдаж буй асуудал байгаа эсэх;
- ◆ Сахилгын зөвлөл болон Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүн, эрх хэмжээ, бүрэн эрхийн хугацааны талаарх зохицуулалт зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт тулгамдаж буй асуудал байгаа эсэх;
- ◆ Цахим зайн гэрчлэлт хийх хэрэгцээ, шаардлага, практикт тулгамдаж буй асуудал байгаа эсэх;
- ◆ Нотариатын мэдэгдэх хуудас зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт тулгамдаж буй асуудал байгаа эсэх;
- ◆ Нотариатчид сахилгын шийтгэл оногдуулах хугацаа, сахилгын шийтгэлийн төрөл зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт тулгамдаж буй асуудал байгаа эсэх.

1.6. Нотариатын тухай хуулийн зарим зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ баримт бичигт дүн шинжилгээ хийх, салбарын мэргэжилтнүүдтэй ганцаарчилсан ярилцлага хийх, ажиглалт хийх зэрэг тоон болон чанарын мэдээлэл цуглуулах нийтлэг аргыг ашигласан.

1.7. Судлагдсан байдлын хувьд хувийн эрх зүйн салбарын цөөнгүй судлаачид бүтээлдээ нотариатын эрх зүйн зохицуулалтын талаар судлан үзжээ. Тухайлбал, Ч.Баянжаргал (2005) Нотариат, Ц.Амарсайхан (2006) Шүүн таслах ажиллагаанд нотариатын гэрчилсэн үйлдэл, бичиг баримтын ач холбогдол, Ч.Батбилэг нар (2013) Нотариат (гарын авлага), А.Оюунчимэг (2007) Нотариатын үйлдэл (Мэргэжлийн аргачилсан зөвлөмж), Ж. Оюунтунгалаг (2013) Харьцуулсан иргэний эрх зүй, С.Должин (2017) Харьцуулсан хувийн эрх зүй судлал, Ч.Баянжаргал (2019) Нотариатын мэдэгдэх хуудас шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл болох нь (МХХ-ны магадлан итгэмжлэгдсэн хичээлийн хөтөлбөр), Р.Онончимэг (2021) Нотариатын байгууллагын түүхэн товчоон (Боть I), Ч.Баянжаргал (2021) Гэрээ, хэлцэл нотариатаар гэрчлүүлэх үндэслэлд хийсэн шинжилгээ, Ч.Баянжаргал (2021) Нотариатын эрх зүйн зарим асуудал, харьцуулсан судалгаа (Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл) зэрэг бүтээлдээ тус тус нотариатын эрх зүйн орчинг боловсронгуй болгоход чиглэсэн онол, практикийн асуудлыг хөндсөн байна.

Хоёр. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлгээ хийх хүрээ, шалгуур үзүүлэлтийн дагуу баримт бичигт дүн шинжилгээ хийхдээ салбар мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, статистик, Монголын Нотариатчидын Танхим болон харьцуулан судлах боломжтой мэргэжлийн зарим холбоо, хороо, зөвлөлийн албан ёсны тайлан, судалгаа, бусад нийтэд нээлттэй мэдээллийг ашиглан доорх Хүснэгт 2-т дурдсан 8 хэсэгт ангилан дүн шинжилгээ хийсэн болно.

2.1. Гэрчлэх чиг үүргийг хэрэгжүүлэгч субъект гадаадын зарим улсын гэрчлэх чиг үүрэг бүхий субъектийн харьцуулалт

Нотариатч нь төрийн зарим чиг үүргийг хуульд заасны дагуу гүйцэтгэж буй этгээд. Нотариатын тухай хууль (2011)-ийн 4 дүгээр зүйлийн 4.3-т Нотариатч нь төрийн нэрийн өмнөөс хөндлөнгийн гэрчийн үүрэг гүйцэтгэж, эд хөрөнгийн болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бус харилцаанд оролцож байгаа этгээдэд эрх зүйн зөвлөгөө өгөх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нотариатын үйлчилгээг нотариатч болон нутаг дэвсгэр, хүн амын байршлын онцлогоос хамааран нотариатын үйлчилгээг нийт иргэдэд хүргэх зорилгоор Нотариатын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т Нотариатч ажиллаагүй сум, тосгонд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс эрх авсан дараах этгээд нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэхээр зохицуулсан байна. Үүнд:

1. Сумын засаг даргын Тамгын газрын дарга эсхүл тус газрын хуулийн мэргэжилтэн;
2. Тосгоны Захирагчийн ажлын албаны дарга.

Мөн зүйлийн 16.3-т Хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газарт хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс эрх авсан албан тушаалтан нотариатчийн чиг үүргийг хавсран гүйцэтгэнэ гэж, 16.4-т нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэж байгаа албан тушаалтанд Нотариатын тухай хуульд заасан эрх, үүрэг, холбогдох бусад зүйл, заалт нэгэн адил хамаарна гэж хуульчилсан байна.

Хүснэгт 3. Монгол Улсад Нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэгчийн тоо⁴

Д/д	Аймаг	Сумын тоо	Эрх авсан	Эрх аваагүй
1	Архангай аймаг	19	17	1 тойрог, 1 эрх аваагүй.
2	Баян-Өлгий аймаг	14	9	3 тойрогтой, 2 эрх аваагүй
3	Баянхонгор аймаг	20	19	1 тойрогтой.
4	Булган аймаг	16, 1 тосгон	14	2 тойрогтой.
5	Говь-Алтай аймаг	18, тосгон 2	14, үүнээс 9 томилогдсон	1 тойрогтой, 3 сум, 2 тосгон эрх аваагүй
6	Говь-сүмбэр аймаг	3	2	1 тойрог, 1 эрх аваагүй
7	Дархан-Уул аймаг	4	1	Шарын гол тойрог, Хонгор эрх аваагүй.
8	Дорноговь аймаг	14	4	2 тойрог, 9 эрх аваагүй
9	Дорнод аймаг	14	13	1 тойрог,
10	Дундговь аймаг	14	13	1 тойрогтой
11	Завхан аймаг	24	23	1 тойрогтой
12	Орхон аймаг	2	2	1 тойрогтой.
13	Өвөрхангай аймаг	19	16	3 тойрогтой.
14	Өмнөговь аймаг	15	11	4 тойрогтой.
15	Сүхбаатар аймаг	13	12	1 тойрогтой.

⁴ Эх сурвалж: Хууль зүй, дотоод хэргийн яам. (2025 оны 4 сарын 17-ны өдрийн байдлаар).

16	Сэлэнгэ аймаг	17 сум, 6 тосгон	16	3 тойрогтой. 4 эрх аваагүй
17	Төв аймаг	27	25	2 тойрогтой.
18	Увс аймаг	19	18	1 тойрогтой.
19	Ховд аймаг	17	15	2 тойрогтой.
20	Хөвсгөл аймаг	23 сум, 1 тосгон	23	1 тойрогтой .
21	Хэнтий аймаг	18	16	2 тойрогтой.

Нотариатын үүргийг хавсран гүйцэтгэгчийн талаарх дээрх тоон мэдээлэлд томилогдсон 279, томилогдоогүй 30 байна. Нотариатын 46 тойрогт ажиллах 318 нотариатчийн орон тоотой ойролцоо тооны нотариатчийн үүрэг гүйцэтгэгчид эрх олгон ажиллуулж байна.

Монгол Улсаас Хилийн чандад суугаа Дипломат төлөөлөгчийн газар: 1/ Элчин сайдын яам 34, 2/ Байнгын төлөөлөгчийн газар 2, 3/Ерөнхий консулын газар, консулын газар 14 нийт 50 газарт⁵ хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс эрх авсан албан тушаалтны тоон мэдээллийг Нотариатын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан үүрэг хавсран гүйцэтгэгчийн судалгааны нэгэн адил нарийвчлан гаргасан байдлаар энэхүү судалгаанд тусгаагүй болно.

Нотариатын тухай хуульд заасан эдгээр албан тушаалтнаас гадна Иргэний хууль (2002)-ийн 64 дүгээр зүйлийн 64.4-т Цэргийн алба хаагчийн итгэмжлэлийг түүний алба хааж байгаа анги, байгууллагын удирдлага, хоригдлын итгэмжлэлийг хорих байгууллагын дарга гэрчилж болно. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017)-ийн 272 дугаар зүйлийн 272.2.7-д Иргэний хуульд заасны дагуу хоригдлын итгэмжлэлийг гэрчлэх гэж хуульчилсан байна. Түүнчлэн Иргэний хуулийн 523 дугаар зүйлийн 523.1-д Гэрээслэлийг бичгээр хийж, үйлдсэн газар, он, сар, өдрийг зааж, нотариатаар, гэрээслэл хийсэн газар нотариат байхгүй бол баг, сумын Засаг даргаар гэрчлүүлнэ. Мөн зүйлийн 523.2-т зааснаар 1/ цэргийн алба хаагчийн гэрээслэлийг түүний алба хааж байгаа цэргийн ангийн удирдлага; 2/ хорих газар хоригдож байгаа буюу ажиллаж байгаа иргэний гэрээслэлийг хорих ангийн дарга; 3/хөлөг онгоцонд зорчиж яваа иргэн болон багийн гишүүдийн гэрээслэлийг онгоцны ахмад тус тус гэрчилсэн тохиолдолд нотариатаар гэрчлүүлсний нэг адил үзнэ гэжээ.

Шигтгээ 1.

Хорих газар хоригдож байгаа хүнд нотариатын үйлчилгээг очиж үзүүлдэг. Иргэний хуулийн холбогдох зохицуулалтад хоригдлын итгэмжлэлийг хорих байгууллагын дарга гэрчилнэ гэж заасан. Гэтэл Иргэний хуулийн 523 дугаар зүйлд хорих газар хоригдож байгаа хүний гэрээслэлийг хорих ангийн дарга гэрчилнэ гэж заасан. Хоригдол, хоригдож байгаа хүн хууль зүйн хувьд оор өөр ойлголт. Нэгэнт хуулиар гэрчлэх чиг үүргийг хэрэгжүүлж болно гэж зохицуулан бол хорих ангийн даргад олгосон гэрчлэх үйлчилгээний хүрээгээр нь хорих ангид хоригдож байгаа этгээд ч мөн адил итгэмжлэл олгодог байх нь хүний эрхийг хангах үүргийн хүрээнд боломжтой гэж үзэж байна.

Нотариаттай хийсэн
ярилцлагын хэсгээс

Дээрх хуулийн зохицуулалтаас харахад хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс эрх авсан гэрчлэх чиг үүргийг хэрэгжүүлэгч субъект нь нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэдэг тул хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй⁶ байх

⁵ Гадаад харилцааны яамны Консулын газрын албан ёсны вебсайт, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газрууд, 2024., <https://www.consul.mn/news/c/162>

⁶ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль (2012)-ийн 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсэг.

шаардлага хуулиар тавигдаж байна. Мөн төрийн гэрчлэх чиг үүргийг хэрэгжүүлэгч субъект (Сумын Засаг даргын Тамгын газрын дарга, эсхүл тус газрын хуулийн мэргэжилтэн, Тосгоны Захирагчийн ажлын албаны дарга, дипломат төлөөлөгчийн газрын албан тушаалтан, цэргийн ангийн удирдлага, хорих ангийн дарга)-ын хүн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээг Нотариатчдын Танхимын нэгдсэн цахим санд бүртгэж, ажиллах нь аливаа эдийн болон эдийн бус харилцаанд хохирол учрахаас урьдчилан сэргийлэх, нотариатын цахим зайн гэрчлэлтийн үйлчилгээг нэвтрүүлэхэд цахим сан үүсгэх зэрэг олон талын ач холбогдолтойг дурдах нь зүйтэй.

Захиалагчийн санал болгосон улс орнуудад нотариатч бус этгээд буюу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн албан хаагч нотариатын чиг үүргийг гүйцэтгэх зохицуулалт байгаа эсэхийг шалгаж үзэхэд Франц Улсын Орон нутгийн засаг захиргааны эрх мэдлийн тухай хуулийн L2122-32 дугаар зүйлд Орон нутгийн Засаг дарга болон түүний орлогч нь иргэний бүртгэлийн баримт бичгийг баталгаажуулах эрхтэй байхаар заасан⁷ нь нотариатын чиг үүргийг гүйцэтгэж байгаад тооцогддог, Сингапур Улсын Шүүхийн тангараг өргөсөн комиссарын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу шүүхэд гаргах баталгаа, мэдэгдлийг шүүхийн тангараг өргөсөн комиссар гэрчлэхээр заасан,⁸ Герман Улсад Холбооны Улсын Нотариатын тухай хуулийн 56 болон 57 дугаар зүйлд зааснаар⁹ нотариатын чиг үүрэг гүйцэтгэх захиргааны ажилтан (administrators for a notary буюу Notariatsverwalter)-ыг Мужийн шүүхийн захиргаанаас томилох бөгөөд тодорхой орон нутагт нотариатч ажиллах боломжгүй үед тухайн нотариатчийн үүргийг ийнхүү томилогдсон этгээд орлон гүйцэтгэдэг байна.

Манай улсад нотариатын зарим үйлдлийг хорих анги, цэргийн ангийн дарга, Сумын засаг даргын Тамгын газрын дарга эсхүл хуулийн мэргэжилтэн, тосгоны захирагчийн ажлын албаны дарга, консул зэрэг зарим төрийн албан хаагчид гүйцэтгэж болохоор заасан нь Герман зэрэг зарим улсынхтай ижил зохицуулалт мөн боловч цаашид мэргэжлийн хуульчаар энэ чиг үүргийг гүйцэтгүүлэх бодлого баримтлах нь зүйтэй гэж дүгнэж байна.

2.2. Нотариатын тойрог, тойрог шилжих

Нотариатын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т Нотариатч тойрог шилжих тохиолдолд мэргэшлийн шалгалт дахин өгөх бөгөөд уг шалгалтад тэнцсэн нотариатч тухайн тойрогт сул орон тоо гаргал дараалал хүлээнэ. Тойрог шилжих журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан байна. Ийнхүү тойрог шилжих зохицуулалтыг хуульчилснаар “Нотариатын тойрог шилжих журам”¹⁰-ыг батлан хэрэгжүүлж байна. Тус журмаар тойрог шилжих хүсэлт гаргагчид тавих шаардлага, мэргэшлийн шалгалт дахин өгөх, тойрог шилжих зэрэг харилцааг журамласан байна.

Монголын Нотариатчдын Танхимын 2021-2025 оны стратеги төлөвлөгөөний зорилт 4-т Ухаалаг байгууллага болно. Монголын Нотариатчдын Танхим нь нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн өөрчлөлт, шинэчлэлтийг цаг тухайд нь хийж, нотариатын үйлчилгээг

⁷ Дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой: https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070633/LEGISCTA000006164545/#LEGISCTA000006164545

⁸ Дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой: <https://sso.agc.gov.sg/SL/322-R3>

⁹ Дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой: https://www.gesetze-im-internet.de/englisch_bnoto/englisch_bnoto.html

¹⁰ Нотариатын тойрог шилжих журам. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал, 2021.. Дугаар А/38.

хүртээмжтэй хүргэх. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд: 1/олон улсын жишиг бүхий нотариатын хууль, эрх зүйн актыг бий болгох, 2/нотариатч хууль хэрэглэх явцад гарч буй шийдвэрлэвэл зохих асуудлыг нэгтгэн судлах, хууль санаачлагчид уламжлах¹¹ гэжээ.

Шигтгээ 2.

Нотариатын тойрог шилжихтээ мэргэшлийн шалгалт дахин өгч, нөөцөд бүртгэгдсэн нотариатчдыг орон тоо гарсан тойрогт томилогүй, анх шалгалт өгч нөөцөд бүртгэгдсэн иргэдтээ томилогоо хийж, байгаад анхаарал хандуулах нь зүйтэй. Манай нотариат ингэж томилогдон ажлаа хийж буй нотариатч мэргэшлийн шалгалт дахин өгч, томилогоо хийж буй байгууллага байхгүй. Тойрог шилжих нь шалгалт ахин томилогдож буй тохиолдолд бол сайн дураараа шалгалт өгч болно гэтэл шалгалт зэрэгтэл ахингүй мөн дахин авах шалгалтын агуулга нь мэргэшсэн байдлыг илтгэхүйц байдлаар боловсруулагдаагүй хуульчийн суурь мэдлэгийг шалгах түвшний агуулгатай байдаг зэргийг эргэн харах, цаашилбал, ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг гадаадын зарим улсын туршлагыг судлан харьцуулан үзэж, оорчлох шаардлагатай.

*Нотариатчтай хийсэн
ярилцлагын хэсгээс*

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль (2012)-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д "хуульч" гэж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй этгээдийг шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчийн сонгон шалгаруулалтад оруулан, тэнцсэн хуульчид эрх олгох, томилох холбогдох хуулийн зохицуулалттай. Тухайлбал,

Нотариатын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д хуульд заасан хуульчийн мэргэжлийн болон энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан мэргэшлийн шалгалтад тэнцсэн; Шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.4-т хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх; Прокурорын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-д Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч, ... Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.1-д хуульд заасны дагуу хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг... тус тус хуульчилсан.

Дээрх хуулийн зохицуулалт бүхий хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй албан тушаалтан (шүүгч, прокурор) болон үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгогдсон хуульч (өмгөөлөгч, нотариатч)-ийн шилжин ажиллах хуулийн зохицуулалт: 1/шүүгчийн өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн шилжүүлэн томилох¹², 2/прокурорын албан тушаалд сонгон шалгаруулах, дэвшүүлэх эсхүл бууруулан томилох, сэлгүүлэн ажиллуулахыг Улсын Ерөнхий прокурорын баталсан журмаар зохицуулдаг¹³ бөгөөд шилжин ажиллах тохиолдолд прокурорын хүсэлтийг үндэслэн Улсын Ерөнхий прокурорын тушаалаар шилжүүлэн ажиллуулдаг байна. Нотариатын байгууллагатай ойролцоо бүтэц, зохион байгуулалттай ажиллаж буй Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчийг шилжин ажиллуулах практикийг судлан үзвэл¹⁴ өмгөөлөгчийн өөр салбарт шилжин ажиллах хүсэлтийг хүлээн авч, төвийн захирлын тушаалаар шилжүүлэн томилдог бөгөөд нотариатын байгууллагаас ялгаатай нь 100 хувь улсын төсвөөс санхүүждэг. Харин нотариатчийн хувьд Нотариатын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д Монголын Нотариатчдын Танхим нотариатын тойрог, түүнд ажиллах нотариатчийн тоог тогтоох саналаа тухайн нутаг дэвсгэрийн хүн амын тоо, нийгмийн хэрэгцээ, шаардлага, нотариатч үйлчилгээний хөлс, орлогоор санхүүжин ажиллах боломж зэргийг харгалзан гаргана гэж хуульчилсан. Нотариатчдын Танхимаас ирүүлсэн 2024 оны тоон

¹¹ Монголын Нотариатчдын танхимын Бүх гишүүдийн хурлын тогтоол. 2021.. Дугаар 08

¹² Шүүхийн тухай хууль (2021)-ийн 43 дугаар зүйл.

¹³ Прокурорын тухай хууль (2017)-ийн 45 дугаар зүйл.

¹⁴ Хууль зүйн туслалцааны төв нь улсын хэмжээнд 37 салбар, өмгөөлөгчтэйгөөр хуульд заасан үндэслэлээр хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлж байна. Эх сурвалж: lac.gov.mn

мэдээлэлд нийт 46 тойрогт 318 нотариатч¹⁵ хуульд заасан төрийн гэрчлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээс 280 нотариатч ажиллаж, 30 орон тоонд томилгоо хийх хэрэгцээ үүсжээ.

Хүснэгт 4. Нотариатын үйл ажиллагаа эрхэлж буй нотариатч (2019-2024)¹⁷

Он	Нотариатч	Түдгэлзүүлсэн	Дуусгавар болсон	Хүчингүй болсон	Идэвхтэй
2019	317	5	10	1	263
2020	311	7	2	6	247
2021	318	5	1	2	279
2022	318	9	3	1	275
2023	318	9	4	3	273
2024	318	8	7	18	279
2025 ¹⁶	318	7	1	1	277

Нотариатын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан үндэслэлээр нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нийт 5 жил хүртэл хугацаагаар түдгэлзүүлэхээр хуульчилсан бөгөөд сүүлийн 7 жилд 50 нотариатчийн зөвшөөрлийг түдгэлзүүлж, мөн хуулийн 18 дугаар зүйлд заасан үндэслэлээр 32 нотариатчийн нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй, мөн хуулийн 19 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 28 нотариатчийн үйл ажиллагааг дуусгавар болгосон байна.

Тайлбар: Нотариатын тухай хуульд нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, дуусгавар болгох зохицуулалтад 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан тул 2019 оны тоон мэдээллийг хамтатган оруулсан болно.

Нотариатчийн хувьд тойрог шилжин ажиллахдаа мэргэшлийн шалгалт дахин өгөх хуулийн зохицуулалтыг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэх зөвшөөрөл бүхий этгээдийн ажил албан тушаал, шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй хууль хэрэглээний практиктай харьцуулахад онцлогтой байна. Төрийн гэрчлэх чиг үүргийг хэрэгжүүлэхдээ нотариатч нь үйлчилгээний хөлс, орлогоороо санхүүжин ажилладаг тул зарим орон нутгийн хүн амын тоо, нийгмийн хэрэгцээ зэргээс шалтгаалан орлогоороо санхүүжих боломж дутмаг, гэр бүлийн болон эрүүл мэндийн гэх мэт шалтгаанаар тойрог шилжин ажиллах хэрэгцээ шаардлага үүсдэг байна.

Нотариатчийн тойрог шилжиж ажиллах тухай үндэсний эрх зүйн зохицуулалтыг судалгааны захиалагчийн санал болгосон гадаадын улс орнуудын эрх зүйн ижил төрлийн зохицуулалттай харьцуулан судалж, үр дүнг улс орноор ангилан дор харууллаа.

Бүгд Найрамдах Франц Улсын нотариатын үйл ажиллагаа

Франц Улс нь хамгийн эртний нотариатын түүхтэй улсуудын нэг гэж албан ёсоор тооцогддог байна. Тухайлбал, хожуу Ромын үед буюу МЭ III зуунд Францын нотариатчидтай төстэй үүрэг гүйцэтгэдэг алба хаагчид төрийн нэрийн өмнөөс гэрээг баталгаажуулдаг байжээ¹⁸.

¹⁵ Нотариатын тойрог, нотариатын тоог тогтоох тухай. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал, 2021.. Дугаар А/10, А/136, А/198.

¹⁶ Монголын Нотариатчдын Танхимаас ирүүлсэн мэдээлэл, 2025 оны I улирал.

¹⁷ Монголын Нотариатчдын Танхимаас ирүүлсэн мэдээлэл, 2024.

¹⁸ Дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоор хангаж үзэх боломжтой: <https://adrianleeds.com/subscribe-to-our-publications/french-property-insider/fpi-archives/notaires-in-france/#:~:text=In%201539%2C%20King%20Francois%201st,custodians%20of%20the%20State%20Seal.>

Франц Улсын нотариатын тухай хууль тогтоомж нь Парламентаас баталсан 1945 оны 45-2590 дугаартай хууль болон 1971 оны 71-1130 дугаартай хууль, 2016 оны 2016-131 дугаартай хууль, Засгийн газраас баталсан Нотариатын мэргэжлээр мэргэшүүлэх, нотариатын чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийн тухай 1973 оны 73-609 дугаартай тогтоол, Зайны болон цахим нотариатыг зөвшөөрөх тухай 2018 оны 2018-1006 дугаар болон 2022 оны 2022-721 дугаар тогтоол зэргээс бүрдэж байна.

Нотариатын газар байгуулах, шилжүүлэх, татан буулгах, нотариатчдын үйлдсэн баримт бичгийн хүчин чадал, үйл ажиллагаа явуулах хүрээ, нотариатчийн тэмдэглэл болон мэргэжлийн бүртгэлийг хадгалах, дамжуулах тухай 1971 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 71-942 тоот тогтоол

Энэхүү тогтоол нь тус улсын Шинэ Каледон, Францын Полинез, Уоллис, Футуна арлуудаас бусад бүх нутаг дэвсгэрийг хамран үйлчлэх¹⁹ бөгөөд тус тогтоолоор нотариатч нь эрх олгосон нутаг дэвсгэрээс гадуур баримт бичиг үйлдсэн бөгөөд энэхүү баримт бичигт оролцогч бүх талууд гарын үсэг зураагүй тохиолдолд хүчингүй байх бөгөөд бүх талууд зурсан байсан ч зөвхөн тэдгээр талуудын хооронд хүчинтэй байх шинжийг агуулдаг байна²⁰.

Харин энэхүү журмын 10 дугаар зүйлд нотариатчдын болон нотариатын ажилтнуудын ажиллах хүрээ нь шүүхийн харьяалалтай ижил байх бөгөөд эрх олгосон нутаг дэвсгэрээс гадуур аливаа үйлдэл хийх нь шударга бус өрсөлдөөнд тооцогдохоор тусган зохицуулж хориглосон байна. Зарим тохиолдолд нотариатчийн хүсэлтээр тус улсын Хууль зүйн сайд нь тодорхой нотариатчийн ажиллах тойргийг өөрчлөн тогтоох, хэд хэдэн салбар нээн ажиллуулах зөвшөөрөл олгож болох бөгөөд энэ нь тухайн нотариатч албан тушаал эрхлэхээ зогсоож дараагийн нотариатч ажиллаж эхлэх үед ч өөрчилсөн тойрог хэвээр үйлчлэхээр тогтоосон байна.

Мөн дээрх 10 дугаар зүйлд нотариатч ажлын байраа татан буулгасан бөгөөд тухайн байршлаас орлого олох боломжтой хэвээр бол өөр нотариатч тухайн ажлын байрыг нь авч ажиллуулж болохоор, түүнчлэн нэг нотариатч салбар байгуулан ажиллуулж болохоор зохицуулсан нь иргэддээ нотариатын үйлчилгээг тогтвортой, хүртээмжтэй хүргэх Франц Улсын төрийн бодлогын хүрээнд баталсан зохицуулалт гэж үзэж болохоор байна.

Манай улсын хууль тогтоомжид нэг нотариатч нэг ажлын байртай байхаар заасан бол Франц Улсад салбар ажлын байр байгуулан ажиллуулах боломжийг бүрдүүлсэн байгаа нь ялгаатай байна.

Хууль зүйн яамнаас 2024 онд баталсан “Нотариатын мэргэжлийн дүрэм, нотариатын мэргэжлийн үйл ажиллагаандаа баримтлах журам”

Энэхүү журамд нотариатчийн мэргэжил болон тус журамд нэр заан дурдсан нэг буюу хэд хэдэн бусад мэргэжлийг хамтатгасан хэлбэрээр салбарын мэргэжилтнүүд нэгдэн мэргэжлийн компани байгуулан түншлэн ажиллуулах боломжтой байхаар заажээ. Мөн энэхүү журмын 6-3 дугаар зүйлд Нотариатчдын дээд зөвлөл нь улсын нутаг дэвсгэр даяар, ялангуяа нотариатчийн ашиг орлого хангалтгүй газарзүйн бүс нутагт нотариатын үйлчилгээг авах боломжийг олгох, мэргэжлийн боловсон хүчнийг бий болгох, ажиллуулахад үзүүлэх тусламжийн санхүүжилтэд зарцуулах заавал төлөх хураамжийг нотариатчдаас авах эрхтэй бөгөөд тус зөвлөлийн санал болгосноор Хууль зүйн сайдын тушаалаар үндэслэл, хувь хэмжээг

¹⁹ Тус тогтоолоор баталсан журмын 8 дугаар зүйл.

²⁰ Тус тогтоолоор баталсан журмын 9 дүгээр зүйл.

тогтоож, зарцуулалтыг Засгийн газар, Парламентад тайлагнахаар зохицуулсан байна. Энэ нь салбарын үйл ажиллагаанд тулгамдсан асуудлыг нотариатчдаас хураамж авах байдлаар шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн сайн жишиг болохуйц зохицуулалт гэж үзэж болохоор байна.

Засгийн газраас баталсан Нотариатын мэргэжлээр мэргэшүүлэх, нотариатын чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийн тухай тогтоол 1973 оны 73-609 дугаартай тогтоол

Энэхүү тогтоолын 49 дүгээр зүйлд ажиллаж байгаа тойргоосоо өөр тойрогт нотариатчийн албан тушаалд томилогдох хүсэлт гаргах бол нотариатаар ажиллаж байгаа хүмүүс тухайн газар нутагт хашиж байгаа нотариатчийн ажлаасаа чөлөөлөгдсөний дараа эсхүл чөлөөлөгдмөгцөө өөр тойрогт томилогдох хүсэлт гаргаж болохоор зохицуулжээ. Ийнхүү огцрох болон шинээр томилогдох хүсэлтээ Хууль зүйн сайдад хүргүүлж нотариатчийн сул орон тоонд томилогдох асуудлаа шийдвэрлүүлдэг байна.

Эдгээрээс дүгнэж үзвэл Франц Улс нь нотариатын үйлчилгээг нэг байрлалд, тогтвортой хүргэх нөхцөлийг бүрдүүлж, нотариатчийн ашиг орлого хангалтгүй газарзүйн бүс нутагт ч нотариатын үйлчилгээг авах боломжийг олгох асуудлыг илүү анхаарч ажилладаг байдал ажиглагдаж байна. Нотариатчийн орлого хангалтгүй нөхцөлд бусад нотариатчдаас хураамж авч орлого багатай нотариатчид зарцуулах байдлаар энэ асуудлыг шийдвэрлэдэг бол манай улсад үндсэндээ нотариатчийн шаардлагыг хангаагүй, хуульчийн эрхтэй эсэх нь тодорхойгүй Засаг даргын тамгын газрын дарга зэрэг тодорхой ур чадвар тогтоогдоогүй албан тушаалтнаар нотариатын үйлдлийг гүйцэтгүүлж байгаа нь зүйтэй эсэхийг дахин судлан үзэх шаардлагатай.

Харин нотариатчийн тойрог шилжих асуудлыг зохицуулахдаа тодорхой тойрогт үйл ажиллагаа явуулж байгаа нотариатч нь тухайн албан тушаалаасаа чөлөөлөгдсөний дараа өөр тойрогт гарсан сул ажлын байранд өрсөлдөх байдлаар өөр тойрогт ажиллах боломж бүрддэг зохицуулалттай нь манай улсын одоогийн зохицуулалттай ойролцоо байна.

Бүгд Найрамдах Эстони Улсын нотариатын үйл ажиллагаа

Эстони Улс нь төрийн цахим үйлчилгээгээрээ танигдсан²¹ бөгөөд ялангуяа зайн болон цахим нотариатын үйлчилгээгээр дэлхийд тэргүүлэгч улс орнуудын нэг юм. Эстони Улсын нотариатын эрх зүйн зохицуулалт нь 2000 оны Нотариатчийн тухай хууль болон 2001 онд батлагдсан Нотариатын үйл ажиллагааны тухай хуулиудаас үндсэндээ бүрэлддэг байна.

Эстони Улсын Нотариатчийн тухай хууль

Энэ хуулийн 8 дугаар зүйлд тус улсад ажиллах нотариатын газрын тоо, тодорхой нотариатчийн харьяалан ажиллах нутаг дэвсгэрийг Хууль зүйн сайд тооцоололд үндэслэн тогтоож, нотариатчдыг томилох бөгөөд нотариатч бүх насаараа томилогдож, тэтгэвэрт гарах нас нь болсон ч дахин 10 жил ажиллах боломжтой байдаг ажээ.

Тус хуулийн 4 дүгээр зүйлд нотариатч нь өөрийн хариуцаж байгаагаас өөр нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах бол албан тушаал, тамга, тэмдгээ Хууль зүйн яаманд хүргүүлж устгуулахаар заасан бөгөөд тойрог шилжин ажиллах хүсэлтээ Нотариатчдын танхимд өгч шийдвэрлүүлнэ. Нотариатчийн сул орон тоо гарснаар хүсэлт шийдвэрлэгдэх үндэслэл бүрдэхээр хуульд зохицуулсан байна.

Тус хуулийн 11 дүгээр зүйлд нотариатч нь нэг ажлын байртай байхаар заасан боловч Хууль зүйн сайдын зөвшөөрлөөр, харьяалагдах нутаг дэвсгэртээ хэд хэдэн ажлын байртай байх боломжтой байхаар, түүнчлэн өөр нотариатчтай гэрээ байгуулсны үндсэн дээр нэг ажлын

²¹ ᠔х сурвалж: <https://e-estonia.com/estoniadigital-enlightenment/>

байрыг хамтран ашиглаж болохоор зохицуулжээ. Мөн нотариатч нь тангараг өргөсөн орчуулагчаас бусад мэргэжлийн төлөөлөлтэй хамт нэг ажлын байранд ажиллахыг хоригложээ.

Эстони Улсын Нотариатын үйл ажиллагааны тухай хууль

Энэхүү хуулийн 2 дугаар зүйлд нотариатч өөрийн нутаг дэвсгэрийн харьяаллаас болон Эстони Улсын нутаг дэвсгэрээс гадуур үйлдсэн нотариатын үйлдэл нь хүчин төгөлдөр бус байх боловч зайнаас гэрчлэх үйлдэл хийсэн тохиолдолд үйлдэл хийсэн газар нь тухайн нотариатчийн үйл ажиллагаа явуулдаг ажлын байр байсан гэж тооцохоор зохицуулсан байна²².

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын нотариатын үйл ажиллагаа

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс нь эрх зүйн хөгжлийн олон жилийн түүхтэй улс бөгөөд нотариатын үйл ажиллагааг Холбооны Улсын Нотариатын тухай хууль (Bundesnotarordnung – BNotO)²³-иар зохицуулдаг байна.

Холбооны Улсын Нотариатын тухай хууль

Энэхүү хуульд зааснаар Герман Улсад бүтэн цагаар ажилладаг, хавсран ажилладаг буюу нотариатаар томилогдсон хуульчид гэсэн хоёр төрлийн нотариатч байх бөгөөд бүтэн цагаар ажилладаг нотариатчийг насаар нь томилдог, 70 нас хүртлээ ажиллах боломжтой байна. Харин өмчийн эрх зүй, хуулийн этгээдийн эрх зүй, гэр бүлийн эрх зүй зэрэг тодорхой чиглэлээр мэргэшсэн нотариатаар томилогдсон хуульчид нь Хуульчдын холбооны гишүүнчлэлийнхээ хугацаагаар томилогдох зохицуулалттай байна.

Энэ хуульд заасны дагуу ХБНГУ-д нотариатч нь тойрогт хамаарах хязгаарлагдмал газар нутагт үйл ажиллагаа явуулах бөгөөд албан ёсны тойрог нь тухайн нотариатчийн байршилд хамаарах бүсийн шүүхийн дүүрэгтэй ижил байна. Харин тус хуулийн 10 дугаар зүйлд зааснаар 100.000 болон түүнээс дээш хүн амтай тойрогт нотариатч өөрөө зөвшөөрснөөр эсхүл шүүхээс шийдвэрлэсний үндсэн дээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тодорхой нэгж, шүүхийн тодорхой харьяаллын хүрээнд ажиллах тойргийг нь Нотариатчдын танхим хязгаарлан тогтоож болно.

Хойшлуулшгүй тохиолдолд эсхүл харьяалах бүрэн эрхт этгээдийн зүгээс зөвшөөрөл олгосон тохиолдолд нотариатч нь тойргоосоо гадуур үйл ажиллагаа явуулах боломжтой бөгөөд зайны гэрчлэлт хийсэн үйлдлийг тойрогтоо хийсэнд тооцно.

Тухайн нотариатч нь ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй байгаа тохиолдолд орлогч нотариатчийг томилж болох бөгөөд орлогч нотариатчийг тухай бүр эсхүл урьдчилан сонгож бэлтгэсэн байж болно.

Нотариатч нь тойрог шилжин ажиллах хүсэлтэй байгаа тохиолдолд Холбооны улсын Нотариатын тухай хуулийн холбогдох зүйлд заасны дагуу Мужийн шүүхийн захиргаагаар дамжуулан Нотариатчдын танхимд хүсэлтээ илгээж шийдвэрлүүлдэг байна.

Бүгд Найрамдах Сингапур Улсын нотариатын үйл ажиллагаа

Сингапур Улсын хувьд 1959 оны Нийтийн албаны нотариатчдын тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар нотариатч нь 7-оос доошгүй жил өмгөөллийн чиглэлээр ажилласан туршлагатай байх шаардлагатай бөгөөд нотариатчийг 12 сараас илүү хугацаагаар томилохгүй, нотариатчийг томилох асуудлыг 1988 оны Сингапурын Хууль зүйн академийн хуульд заасан Сингапурын Хууль зүйн академийн “Сенат” хариуцан шийдвэрлэхээр тогтоосон байна.

²² Дэлгэрэнгүйг дараах холбоосоор үзэх боломжтой: https://www.gesetze-im-internet.de/englisch_bnoto/englisch_bnoto.html

²³ Дэлгэрэнгүйг дараах холбоосоор үзэх боломжтой: https://www.gesetze-im-internet.de/englisch_bnoto/englisch_bnoto.html

Энэхүү хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт нотариатч бүр Сингапур Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж болно гэж заасан буюу нотариатч нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах эрхтэй, тодорхой тойрог эсвэл газар нутгаар хязгаарлагдахгүй онцлогтой байна. Өөрөөр хэлбэл Сингапур Улсад тойрог шилжих тухай зохицуулалт шаардлагагүй байна.

Мөн дээрх хуулийн 3 дугаар зүйлд Нотариатчийг 12 сараас дээш хугацаагаар түр томилохгүй бөгөөд нотариатч Сингапур Улсад 1 сараас дээш хугацаагаар байхгүй гэж үзэж байгаа бол Сенатын зүгээс Сингапурт ажиллаж буй өмгөөлөгч, хуульч аливаа хүнийг оронд нь түр хугацаагаар нотариатчаар томилж болно.

Түүнчлэн мөн хуулийн 3 дугаар зүйлийн 4-7 дахь хэсгүүдэд Сенат нь нотариатчийн томилгоог хийхээс өмнө өргөдөл гаргагчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахыг санал болгож буй газар нутагт үйл ажиллагаа явуулж байгаа нийтийн албаны нотариатчдын тоо болон тухайн газарт оршин суугчдын тав тухыг харгалзан үзэж хүсэлт гаргасан нотариатчийг томилох эсхүл татгалзах бүрэн эрхтэй байх бөгөөд тухайн шийдвэрт гомдол гаргах эрхгүй, нотариат томилсон тохиолдол бүрийг Хуулийн сэтгүүлд нийтэлж байхаар тус тус зохицуулжээ.

Тус хуулийн хүрээнд 1999 онд баталсан “Нийтийн албаны нотариатын дүрэм”-ээр нотариатчаар томилогдох, дахин томилогдох өргөдлийн хураамж болон нотариатчаар томилогдсон болон дахин томилогдсон тохиолдолд төлөх эргэн олгогдохгүй төлбөр, түүнчлэн Сингапурын Хууль зүйн академид төлөх бусад төлбөр, хураамжийг зохицуулдаг байна.

Эдгээрээс дүгнэж үзвэл Монгол Улсын хувьд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид үндэслэн нотариатын тойргийг тогтоож, нэг тойрогт хүн амын нягтралаас хамааран тодорхой тооны нотариатч ажиллаж боломжтой байхаар зохицуулсан бөгөөд нотариатчийн орлого олох боломжийг төдийлөн сайтар тооцоогүй байдал ажиглагдаж байна. Харин Франц Улсад нотариатчийн орлого хангалтгүй нөхцөлд бусад нотариатчдаас хураамж авч орлого багатай нотариатчид зарцуулах байдлаар энэ асуудлыг шийдвэрлэдэг байна.

Тойрог шилжин ажиллахтай холбоотой асуудлыг бусад улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулж судалбал ерөнхийдөө тодорхой газар нутгаас өөр газар нутагт шилжин ажиллахдаа нотариатч нь өмнө ажиллаж байсан нотариатчийн албан тушаалаасаа чөлөөлөгдөж байж, дараагийн газартаа нотариатчаар ажиллах хүсэлт гаргадаг жишиг нийтлэг байх боловч манай улсын адил нотариатчийн мэргэшлийн шалгалт дахин өгөх шаардлага тавьдаг туршлага ажиглагдсангүй. Манай улсын хувьд нотариатын тойрог шилжих мэргэшлийн шалгалт дахин өгөөд тухайн шалгалтад тэнцээгүй нотариатчийг одоо ажиллаж буй ажлын байранд ажиллуулж байгаа нь тэгш байдлын зарчимд нийцэхгүй болно. Иймд тойрог шилжих шалгалт дахин өгөөд тухайн шалгалтад тэнцээгүй нотариатчийг үндсэн тойрогт нь үргэлжлүүлэн ажиллуулж буй одоогийн туршлагыг өөрчлөх шаардлага цаашид үүсэхийг үгүйсгэх аргагүй юм.

Монгол Улсын Нотариатын тухай хуульд нотариатын шалгалтыг 3 жил тутамд зохион байгуулах, шалгалт зохион байгуулаагүй жилд нотариатчдын нөөцөөс томилохоор зохицуулсан бол харьцуулан судалсан бусад улсын хувьд нотариатчийн нөөц гэсэн ойлголт байхгүй нотариатын эрхтэй эсхүл тодорхой ур чадвартай бусад этгээдийг сул орон тоонд түр ажиллуулах байдлаар шийдвэрлэдгээрээ ялгаатай байна. Манай улсын нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, нотариатын тойрог шилжихтэй холбогдсон шалгалтад тэнцсэн хуульчдаас сул орон тоонд өрсөлдүүлэн томилж байгаа тохиолдолд тэдгээр иргэдээс нөөц бүрдүүлэх шаардлагагүй тул ийнхүү нөөц бүрдүүлэх тухай зохицуулалтыг

хүчингүй болгож, тойрог шилжих тохиолдолд өмнө хашиж байсан нотариатчийн албан тушаалаасаа чөлөөлөгдсөний дараа шалгалтад өрсөлдөн томилогдох боломжтой болгож эрх зүйн зохицуулалтад өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэж байна. Эдгээр өөрчлөлтийг оруулснаар эрх зүйн зохицуулалт практикт нийцнэ гэж үзэж байна.

2.3. Нотариатчдын танхимын дэргэдэх Сахилгын зөвлөлийн бүрэлдэхүүн, эрх хэмжээ, бүрэн эрхийн хугацаа

Нотариатын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д Нотариатчдын Танхимын дэргэдэх Сахилгын зөвлөл нь нотариатчийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэх, чиг үүрэгтэй ажилладаг. Тус зөвлөлийн бүрэлдэхүүнд шүүх, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл тус бүр хоёр. Танхимаас гурав, нийт долоон гишүүнтэйгээр ажиллаж байна. Нотариатын тухай хуульд 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулахаас өмнөх Сахилгын зөвлөлийн эрх хэмжээг “Монголын Нотариатчдын Танхимын дүрэм”-ийн 12 дугаар зүйлийн 12.2, “Сахилгын зөвлөлийн дүрэм”-ийн 13 дугаар зүйлийн 13.2-т зааснаар Сахилгын зөвлөлийг 7-9 хүний бүрэлдэхүүнтэйгээр 4 жилийн хугацаагаар сонгон байгуулж²⁴ байжээ. Сахилгын зөвлөлийн бүрэлдэхүүн нь дан ганц нотариатын байгууллагын төлөөллөөс бүрдэж байсныг өөрчлөн “Сахилгын зөвлөлийн ажиллах журам”-ыг 2019, 2023²⁵ онд шинэчлэн баталсан байна. Ийнхүү Сахилгын зөвлөлийн бүрэлдэхүүнд нотариатчдаас гадна бусад хууль зүйн салбарын төлөөллийг оруулан хуульчилсан нь Нотариатын тухайн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнд хөндөгдсөн 1/ нотариатчийн үйл ажиллагаанд хяналт тавих, сахилгын шийтгэл оногдуулах эсэх асуудлыг адил статус бүхий нотариатчид хэрэгжүүлдэг 2/ сахилгын зөвлөл өөрөө өөрийнхөө асуудлыг шийдвэрлэдэг²⁶ гэсэн шүүмжлэл дагуулсан зохицуулалтыг өөрчилсөн, зөвлөлийн хараат бус бие даасан байдлыг дээшлүүлсэн зорилгоо биелүүлсэн зохицуулалт гэж үнэлж байна.

Монголын Нотариатчдын Танхимын 2021-2025 оны стратеги төлөвлөгөөний Зорилт 3-т Нотариатч ёс зүйтэй ажиллана. Нотариатч нь хуульчийн болон нотариатчийн ёс зүйг чанд сахин үйл ажиллагаа явуулна. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд 1/ мэргэшлийн ёс зүйн хэм хэмжээний онолын судалгаа хийх, 2/мэргэжлийн болон мэргэшлийн ёс зүйн хэм хэмжээг онолын үүднээс ангилах²⁷ зэрэг ажлыг тусгажээ.

Шигтгээ.3

Сахилгын зөвлөл холимог бүрэлдэхүүнтэй боленоор, тус зөвлөлийн ажиллах журмыг өөрчлөн 2019 онд батлан, 2020 онд нэмэлт өөрчлөлт оруулсан. Улмаар сахилгын зөвлөлд нрүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад процессын зарим зохицуулаагүй орхингдуулсан ажиллагааг журамдаа нэмж тусгах хэрэгцээ шаардлага буйг шүүгч зөвлөлийн гишүүдийнхээ тусламжтайгаар тодорхойлон 2023 онд Сахилгын зөвлөлийн ажиллах журмаа шинэчлэн батлуулан ажиллаж байна. Сахилгын зөвлөлийг хуулиар холимог бүрэлдэхүүнтэй болгосон нь олон нийтийн дунд үүсээд байсан ёс зүйн зорчил гаргасан нотариатчийн зөрчлийг шалган шийдвэрлэхэд ашиг сонирхлын зорчил үүсдэг, хонгон шийтгэл оногдуулдаг, дотогшоо чиглэсэн үйл ажиллагаатай нээлттэй бус гэсэн шүүмжлэл, хардлагыг өөрчлөх эхний бодитой алхам болсон гэж харж байгаа.

Сахилгын зөвлөлийн гишүүнтэй хийсэн ярилцлагын хэсгээс

²⁴ Монголын Нотариатчдын танхимын дүрэм, Монголын Нотариатчдын танхимын бүх гишүүдийн хурлын тогтоол, 2011 оны Дугаар 07.

²⁵ Монголын Нотариатчдын танхимын дэргэдэх “Сахилгын зөвлөлийн ажиллах журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал, 2023.. Дугаар А/77.

²⁶ Нотариатын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, Судалгааны тайлан, Уб., 2018, 297 дахь тал

²⁷ Монголын Нотариатчдын танхимын Бүх гишүүдийн хурлын тогтоол, 2021.. Дугаар 08.

Нотариатын тухай хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Сахилгын зөвлөлийг холимог бүрэлдэхүүнтэйгээр байгуулахаар хуульчилсан нь нотариатын байгууллагын хараат бус, бие даасан, ил тод, хууль ёсны байдлыг хангах чухал зохицуулалт болсон хэдий ч тухайн зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа болон шүүх, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллийг хэрхэн бүрэлдэхүүндээ оруулан батламжлах талаарх зохицуулалтыг тусгалгүй орхигдуулжээ.

Нотариатчдын Танхимын дэргэдэх Сахилгын зөвлөлтэй ижил чиг үүрэг бүхий шүүх, прокурор, өмгөөллийн байгууллагын сахилга, ёс зүйн зөвлөл, хорооны бүрэлдэхүүн, чиг үүрэг, бүрэн эрхийн хугацааг харьцуулан судлан үзвэл:

Шүүхийн сахилгын хороо – Шүүхийн захиргааны тухай хууль (2012)²⁸-ийн 32 дугаар зүйлд Шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх эрх бүхий Шүүхийн Ёс зүйн хороо нь нэр хүндтэй хуульч, эрдэмтэн, судлаач зэрэг есөн гишүүний бүрэлдэхүүн (анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тус бүр нэг, Хуульчдын холбооноос гурав, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гурван хүний нэрийг дэвшүүлнэ)-тэй, улсын хэмжээнд нэг байна, бүрэн эрхийн хугацаа гурван жил байх бөгөөд түүнийг нэг удаа улируулан томилж болно, ёс зүйн хороо нь ажлын албатай байх бөгөөд Ерөнхий зөвлөлийн ажлын албанд харьяалагдана гэж хуульчилсан бөгөөд энэхүү бүтэц зохион байгуулалт (2013-2021)²⁹-аар ажиллажээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр бие даасан орон тооны холимог бүтэц бүхий Шүүхийн сахилгын хороог 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр³⁰ байгуулсан бөгөөд Шүүхийн тухай хууль (2021)-ийн 95 дугаар зүйлд Сахилгын хороо нь Шүүхийн тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий бие даасан орон тооны 9 гишүүн (дөрвөн гишүүнийг хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах шатны шүүхээс хоёр, анхан шатны шүүхээс нэг шүүгчийг нийт шүүгчийн чуулганаас нууц санал хураалтаар сонгож, шүүгч бус таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилж байна)-тэй, бүрэн эрхийн хугацаа 6 жил, улсын хэмжээнд нэг ажиллана, хорооны даргыг гишүүд дотроосоо нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа сонгоно гэж хуульчилсан байна.

Прокурорын ёс зүйн зөвлөл - Прокурорын тухай хууль (2017)-ийн 65 дугаар зүйлд Прокурорын ёс зүйн зөвлөл нь прокурор ёс зүйн дүрэм зөрчсөнтэй холбоотой асуудлыг шалгах, дүгнэлт гаргах эрх бүхий орон тооны бус гишүүнтэй, тус бүрэлдэхүүн (Улсын ерөнхий прокурорын газар, хэлтсийн дарга, ахлах прокурор, аймаг, нийслэлийн прокурорын газрын ерөнхий прокурор нарын дан ганц)-ийг Улсын ерөнхий прокурор томилж³¹, харин “Прокурорын ёс зүйн дүрэм”, “Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”³²-ын 4 дүгээр зүйлд Зөвлөл нь дадлага туршлага, ур чадвартай, мэргэжил, ёс зүйн зөрчилгүй прокуроруудаас бүрдэх бөгөөд дарга, 8 гишүүний бүрэлдэхүүнтэй, 3 жилийн хугацаагаар Улсын ерөнхий

²⁸ Шүүхийн захиргааны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, 2021.01.15

²⁹ Монгол Улсын шүүхийн сахилгын хороо (түүхэн хөгжил), 2023., 34-41 дэх тал.

³⁰ Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүдийг томилох тухай, УИХ-ын тогтоол, 2021., Дугаар 92.

³¹ Прокурорын ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай, Монгол Улсын ерөнхий прокурорын тушаал, 2021. Дугаар А/18.

³² Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, 2018., Дугаар 10. Хавсралт II.

прокурор томилж, зөвлөлийн гишүүнийг өөрчлөх, хугацааг сунгах шийдвэрийг Улсын Ерөнхий прокурор бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэдэг байна.

Прокурорын ёс зүйн зөвлөл болон Улсын ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөлийн хараат бус, нээлттэй ил тод байдлыг бэхжүүлэхэд холимог бүрэлдэхүүн бүхий зөвлөлийг байгуулах, ийнхүү байгуулахдаа Улсын ерөнхий прокуророос хамаардаггүй байдлаар зохицуулах хэрэгцээ, шаардлага буйг судалгаанд³³ дурдсан байна.

Монголын Өмгөөлөгчдийн холбооны дэргэдэх мэргэжлийн хариуцлагын хороо – Өмгөөллийн тухай хууль (2019)-ийн 32 дугаар зүйлд Мэргэжлийн хариуцлагын хороо нь өмгөөлөгч хууль болон Ёс зүйн дүрмийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, энэ хууль болон Ёс зүйн дүрмийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх талаар зөвлөмж гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Тус хороо нь шүүгч, прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, иргэдийн төлөөлөл тус бүр 1, Өмгөөлөгчдийн Холбооны төлөөлөл 7, нийт 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил, гишүүнийг нэг удаа улируулан сонгож болно гэж хуульчилсан. Түүнчлэн тус хорооны бүрэлдэхүүнд орж буй иргэдийн төлөөлөл нь өмгөөллийн үйл ажиллагааны талаар хувийн ашиг сонирхолгүй, хуульч бус, өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлж байгаагүй Монгол Улсын иргэн байх бөгөөд түүнд тавих шаардлага, сонгох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална мөн шүүх, прокурорын төлөөлөл нь шүүгч, прокуророор долоогоос доошгүй жил ажилласан шүүгчийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн, прокурорыг Улсын ерөнхий прокурорын, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор батламжилна гэжээ.

Шүүхийн сахилгын хороог Үндсэн хуульд нэр дурдан, бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг Шүүхийн тухай хуулиар тогтоосон болно. Мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д Ерөнхий зөвлөл болон Сахилгын хорооны гишүүнээр сонгогдсоноор шүүгчийн бүрэн эрх нь түдгэлзсэнд тооцогдох бөгөөд дараагийн гишүүн сонгогдсоноор бүрэн эрх нь сэргэнэ гэж заасан. Харин өмгөөлөгч, нотариатчийн ёс зүйн зөрчлийн талаарх өргөдөл, гомдлыг шалган шийдвэрлэж буй хороо, зөвлөлийн бүрэлдэхүүн (орон тооны бус)-д шүүгчийг ажиллуулахаар хуульчилсан нь Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.16-д заасан багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсрах гэсэн заалттай зөрчилдөж байна. Хэдийгээр Шүүхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12-т хуульд заасан бусад бүрэн эрх гэж бусад салбар, мэргэжлийн хуулиар шүүгчийг аливаа зөвлөл, хороонд оруулан батламжлах, томилох, шүүхэд үүрэг болгосон, эрх олгосон зохицуулалт нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд дотоод болон гадаад хүчин зүйлийн нөлөөлөл үүсэх талтайг дурдах нь зүйтэй.

Шигтгээ 4.

Сахилгын зөвлөлийн бүрэлдэхүүнд орж буй шүүгчдийн хувьд ямар зарчмаар шалгарч зөвлөлийн бүрэлдэхүүнд орсноо тодорхой мэдээгүй байгаа нь зөвлөлийн бүрэлдэхүүнд орох урьдчилсан нөхцөл шаардах хэрэгцээ үүсэх эсэх. Мөн зөвлөлийн бүрэн эрхийн хугацааг дүрэм, журамд бусад хуулиар тогтоох. Ийнхүү хуульчлахдаа шингээр байгуулагдсан зөвлөлийн үйл ажиллагаа нь жигдрэх хүргэлх хугацаа, манай зөвлөлдөөс бусад зөвлөл, хорооны бүрэн эрхийн хугацааг харгалзан үзэх шаардлагатай.

Сахилгын зөвлөлийн гишүүнтэй
хийсэн ярицлагын хэсгээс

³³ Прокурорын хараат бус байдал: прокурорын байгууллагын тогтолцоо, удирдлага, өөрөө удирдах байгууллага. Эрүүгийн эрх зүйд холбогдох судалгааны тайлангийн эмхтгэл, 2024, УБ., 402-424 дэх тал.

Шүүхийн төлөөлөл, шүүгчийг зөвлөл, хороонд оруулан батламжилж буй өнөөгийн практикт нь тухайн шатны шүүхэд ирүүлсэн албан бичиг, салбарын хуулийн холбогдох зохицуулалттай танилцсанаар шүүгчийг орон тооны бус зөвлөл, хорооны бүрэлдэхүүнд танхимын тэргүүн шүүгч танилцуулж, санал авч нэрийг нь илгээдэг мөн тухайн шүүхэд хянагддаг шийдвэрийг гаргадаг зөвлөл, хорооны бүрэлдэхүүнд ажилладаг зэрэг нь шүүхийн мэргэжлийн удирдлагын нөлөөлөл, шүүгчийн ёс зүйн зөрчилд ч цаашид тулгамдсан асуудлын нэг болохыг үгүйсгэх аргагүй юм.

Харьцуулан судалсан зөвлөл, хороог холимог бүрэлдэхүүнтэй байгуулахаар хуульчлахдаа тухайн зөвлөл, хорооны чиг үүргийг хэрэгжүүлэх, бие даасан хараат бусаар ажиллах хууль зүйн орчин нөхцөлийг бүрдүүлэн холимог бүрэлдэхүүнд 2-3 салбарын төлөөллийн оруулсан байна. Харин прокурорын байгууллагын хувьд дан ганц прокурорын төлөөллөөс бүрдсэн ёс зүйн зөвлөл ажиллаж байгаа бол өмгөөллийн байгууллагын хувьд бүрэлдэхүүний дийлэнх олонхийг Өмгөөлөгчдийн холбооны төлөөлөл бүрдүүлж байна. Үүнээс дүгнэхэд Нотариатчдын Танхимын дэргэдэх Сахилгын зөвлөлийн бүрэлдэхүүнд салбарын онцлог, үйл ажиллагааны хүрээнд нийцүүлэн нотариатын төлөөллийг ердийн олонх байхаар, хувийн эрх зүйн салбарын хуульч профессорууд, өмгөөллийн байгууллагын төлөөллийг бүрэлдэхүүндээ оруулах нь илүү тохиромжтой байх болов уу. Ийм бүрэлдэхүүнтэй байвал гишүүдэд урьдчилсан нөхцөл тавьж болох юм.

Дээрх харьцуулан судлан үзсэн шүүх, прокурор, өмгөөллийн зөвлөл, хорооны бүрэн эрхийн хугацааг 3-6 жилээр хуульчилсан байна. Энэхүү бүрэн эрхийг хугацааг 3 жилээр хуульчилсан тохиолдолд тухайн хугацаагаар нэг удаа улираах, эсхүл зөвхөн нэг удаа 6 жилээр томилж, сонгож болох зохицуулалт нийтлэг байна. Нотариатчдын Танхимын дэргэдэх Сахилгын зөвлөлийн бүрэн эрхийн хугацааг хуульчлаагүй орхигдуулсан байх тул ижил төстэй хороо, зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа тус зөвлөлийн мэргэшин ажиллаж буй байдал, бүрэлдэхүүний чадавх, удирдлагын бүрэн эрхийн хугацаа зэргийг судлан үзсэн болно. Тухайлбал, Монголын Өмгөөлөгчдийн холбооны Их хурал 3 жилд нэг удаа, тус их хурлаас сонгогдсон Удирдах зөвлөл, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 3 жил, мөн Мэргэшлийн хороо, Мэргэжлийн хариуцлагын хорооны бүрэн эрхийн хугацаа нь 3 жил байна гэж хуульчилсан байна.

Монголын Нотариатын танхимын хувьд бүх гишүүдийн хурлаар Ерөнхийлөгч, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, Мэргэшлийн хороог 4 жилээр байгуулж байх тул Сахилгын зөвлөлийн бүрэн эрхийн хугацааг мөн адил 4 жилээр хуульчлах боломжтой юм.

2.4. Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүн, эрх хэмжээ, бүрэн эрхийн хугацаа

Нотариатын тухай хуулийн 15 дугаар зүйлд Нотариатчийн мэргэшил, ур чадварын түвшинд дүгнэлт гаргах, мэргэшлийн шалгалт явуулах чиг үүрэг бүхий Мэргэшлийн хороо хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана. Мэргэшлийн хороо долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд даргыг нь гишүүдийн олонхийн саналаар тэдгээрийн дотроос сонгоно. Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд шүүх, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Танхимаас тус бүр хоёр, эрдмийн зэрэг цолтой хуульч нэг хүний төлөөлөл байна. Мэргэшлийн хорооны гишүүн хууль зүйн магистр болон түүнээс дээш эрдмийн зэрэг, цолтой, хууль зүйн, эсхүл нотариатчийн ажлын туршлагатай, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байна. Мэргэшлийн хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байх ба тэдгээрийг улируулан томилохгүй. Мэргэшлийн хорооны нөхөн томилогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан

гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна. Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална³⁴ гэж хуульчилсан байна.

Монголын Нотариатчдын Танхимын 2021-2025 оны стратеги төлөвлөгөөний Зорилт 2-т Нотариатч ур чадвартай болно. Нотариатын тухай хууль, Нотариатын үйлдэл хийх заавар болон холбогдох эрх зүйн актыг удирдлага болгон нотариатын үйлдлийг хууль тогтоомжид нийцүүлэн хийх ур чадварыг эзэмшсэн байх. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд: 1/ нотариатын үйлдэл гэрчлэх нэгдмэл ойлголтыг бий болгох үүднээс мэргэшлийн, сургалтад хамрагдаж жишиг тогтоох, нотариатчийг мэргэшүүлэх, давтан сургах, ур чадварыг дээшлүүлэх, 2/судалгаанд суурилсан сургалтын бодлогыг тодорхойлж, сургалт явуулах³⁵ гэж тусгажээ. Мэргэшлийн хороо нь нотариатчийн мэргэшил, ур чадварын түвшинд дүгнэлт гаргаж ажилладаг тул нотариатчийн мэргэшил, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулахад санал, зөвлөмж өгөх боломжтой байна.

Шигтгээ 5.

Мэргэшлийн хороонд олон талын хуулийн байгууллагын төлөөллийг оролцуулж байгааг ор тас үгүйсгэж болохгүй байх. Тэгэхдээ төлөөллийн квот, хувь хэмжээ бага байх ёстой гэж бодож байгаа юм. Яагаад гэвэл мэргэжлийн хороотой холбоотой гомдол гарах юм бол яам шийдвэртэйх байтал мэргэжлийн хороонд яамны төлөөлөл орсон. Шийдвэртэйх шийдвэрийг яам өөрөө хянаж шийдвэртэйх түүний эерэг шийдэх үү гэдэг асуудал. Тэгээд дээд шүүхийн шүүгч гишүүнээр байгаа бүрэлдэхүүний шийдвэрийг захиргааны хэргийн анхан шатны шүүхэд өгөхөөр дээд шатны шүүгч шийдчихсэн байхад захиргааны хэргийн шүүгч шийдвэртэйх нь бас асуудалтай

Нотариатчдын Танхимын төлөөлөлтэй
хийсэн ярилцлагаас

Мэргэшлийн хороо 1/ нотариатчийн мэргэшил, ур чадварын түвшинд дүгнэлт гаргах- Нотариатчийн мэргэшлийн хорооны ажиллах журмын 5.4-т Нотариатчийн мэргэшил, ур чадварын түвшинд дүгнэлт гаргахдаа хууль хэрэглэх, нотариатын үйлдэл хийх, бичиг баримт боловсруулах, эрх зүйн зөвлөгөө өгөх чадварын түвшингийн талаарх дүгнэлт, 2/мэргэшлийн шалгалт явуулах, мөн журмын 2.10-т мэргэшлийн шалгалтын сорилго, бодлогыг Мэргэшлийн хороо боловсруулж бэлтгэх бөгөөд нууцлалыг бүрэн хариуцах, Нотариатын тойрог шилжих мэргэшлийн дахин өгөх шалгалтыг³⁶ тус тус зохион байгуулж, ажилладаг байна.

Шүүх, прокурор, өмгөөллийн байгууллагын зөвлөл, хорооны бүрэлдэхүүн, чиг үүрэг, бүрэн эрхийн хугацааг харьцуулан судлан үзвэл:

Шүүхийн ерөнхий зөвлөл нь Үндсэн хуульд заасан 1/ шүүгчийг шилж олох, 2/ шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хангах гэсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 3.4 дэх хэсэгт, Шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлд Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд шүүгч 5 гишүүн(хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах болон анхан шатны шүүхээс тус бүр хоёр шүүгчийг Нийт шүүгчийн чуулганаас нууц санал хураалтаар сонгож)-ийг, шүүгч бус 5 гишүүн (нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно.)-ийг сонгож, томилно. Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил, зөвхөн нэг удаа ажиллана. Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд тавигдах шаардлага болон зөвлөлийн даргыг сонгох, зөвлөлийн нөхөн сонгогдсон, томилогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна гэж хуульчилсан байна.

³⁴ Нотариатчийн мэргэшлийн хорооны ажиллах журам. Хууль зүйн сайдын тушаал, 2016.. Дугаар А/06. Хавсралт I.

³⁵ Монголын Нотариатчдын танхимын Бүх гишүүдийн хурлын тогтоол, 2021.. Дугаар 08

³⁶ Нотариатын тойрог шилжих журам. Хууль зүйн сайдын тушаал, 2021.. Дугаар А/38.

Монголын Өмгөөлөгчдийн холбооны дэргэдэх Мэргэшлийн хороо³⁷ нь Өмгөөллийн тухай хуулийн 46 дугаар зүйлд зааснаар Өмгөөлөгчийн шалгалт болон үргэлжилсэн сургалт зохион байгуулах чиг үүрэгтэй, есөн гишүүний бүрэлдэхүүн(хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, иргэдийн төлөөлөл тус бүр нэг хүнийг, Өмгөөлөгчдийн Холбооноос долоон гишүүн(төлөөллийн гурав нь хуульч эрдэмтэн)-ийг санал болгож, Өмгөөлөгчдийн Холбооны Удирдах зөвлөл батламжилж, томилно)-тэй, дарга болон гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байна гэж хуульчилсан.

Мэргэшлийн хороо нь чиг үүргийн хүрээнд 1/өмгөөлөгчийн шалгалтыг хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, өмгөөлөгчийн ёс зүйн талаарх мэдлэг, мэтгэлцэх ур чадвар эзэмшсэнийг тогтоох³⁸, 2/үргэлжилсэн сургалт зохион байгуулах³⁹, өмгөөлөгчийн мэргэшлийн мэдлэг, ур чадвар, мэргэшсэн байдлыг шинжлэх ухааны орчин үеийн онол, үзэл баримтлал, эрх зүйн шинэтгэлийн хандлага, практикт нийцүүлэн дээшлүүлж, мэргэжлийн ёс зүйг чанд мөрдөж, шударга хараат бусаар тууштай ажиллах чадварыг төлөвшүүлэх зорилготой ажилладаг байна.

Прокурорын мэргэжлийн хороо нь Прокурорын тухай хуулийн 64 дүгээр зүйлд Прокурорын мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шалгах, дүгнэлт гаргах эрх бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл юм.

Прокурорын мэргэжлийн дүрэм⁴⁰, мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг⁴¹ Монгол Улсын Ерөнхийлөгч баталж, мэргэжлийн хороог Улсын ерөнхий прокурорын орлогч, Улсын ерөнхий прокурорын хэлтсийн дарга нар, аймаг, нийслэл, дүүргийн ерөнхий прокуророос бүрдсэн 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр Монгол Улсын ерөнхий прокурор байгуулсан байна⁴². Тус зөвлөл нь прокурорын мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой 1/прокурор мэргэжлийн үйл ажиллагааны алдаа гаргасан эсэх талаар дүгнэлт гаргуулахаар Дээд шатны прокуророос ирүүлсэн хүсэлт, 2/хяналтын ажлын алдаа гаргасан үндэслэлээр жилд 3 буюу түүнээс дээш удаа сахилгын арга хэмжээ авагдсан прокурорыг тухайн албан тушаалд, эсхүл прокурорын үүрэгт ажилд тэнцэх эсэх талаар дүгнэлт гаргуулахаар Дээд шатны прокуророос ирүүлсэн хүсэлт, 3/ өөрийн гаргасан шийдвэрийг үндэслэлтэй гэж үзэж, тухайн шийдвэрийн талаар Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн прокурорын хүсэлтийг үндэслэн шалгах, дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Прокурорын мэргэжлийн хороонд зөвхөн прокурор хүсэлт гаргах шийдвэрлүүлдэг байна.

Эвлэрүүлэн зуучлалын зөвлөл нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль (2012)-ийн 10 дугаар зүйлд заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэд эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, гэрчилгээ олгох, бэлтгэх, давтан сургах ажлыг зохион байгуулах чиг бүхий, шүүгч, өмгөөлөгч, судлаач зэрэг таван хүний бүрэлдэхүүн(орон тооны бус)-тэй, 4 жилийн хугацаагаар байгуулагдан, тус Зөвлөлийн дарга, гишүүнийг томилж, чөлөөлөх, Зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийг⁴³ Шүүхийн ерөнхий зөвлөл батална гэсэн

³⁷ МОХ-ийн Мэргэшлийн хорооны ажиллах журам

³⁸ Өмгөөлөгчийн шалгалт зохион байгуулах журам, МОХ-ны Удирдах зөвлөлийн тогтоол, 2021. Дугаар 49

³⁹ МОХ-ны Мэргэшлийн хорооны ажиллах журам, МОХ-ны Удирдах зөвлөлийн тогтоол, 2021. Дугаар 14. Хавсралт I.

⁴⁰ Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, 2018., Дугаар 11. Хавсралт I.

⁴¹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, 2018., Дугаар 11. Хавсралт II.

⁴² Монгол Улсын ерөнхий прокурорын тушаал, 2022., Дугаар А/90.

⁴³ Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм, Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоол, 2022. Дугаар 110.

зохицуулалтын 2021 оны 1 дүгээр сарын 15-ны хуулиар нэмсэн байна⁴⁴. Мөн хуулийн 11 дүгээр зүйлд эвлэрүүлэн зуучлалын зөвлөлийн бүрэн эрхийг хуульчилсан байна.

Эвлэрүүлэн зуучлалын зөвлөл нь Шүүх, прокурор, өмгөөлөл, нотариатын байгууллагын Мэргэшлийн болон Сахилга, ёс зүйн зөвлөл, хорооны чиг үүргээр нь зааглан 2 тусдаа байгуулагдан ажиллаж буй зөвлөл хорооны чиг үүргийг нэгтгэн хэрэгжүүлж буй, түүнчлэн гишүүнд нэр дэвшүүлэх нээлттэй зарыг⁴⁵ Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлж, нэр дэвшигчийн материалыг Ажлын алба хүлээн авч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуралдаанд танилцуулдаг байна. Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид 1/ эрх зүйн дээд боловсролтой, 2/ иргэний эрх зүйн чиглэлээр болон эвлэрүүлэн зуучлах ажлын туршлагатай, 3/ эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байх гэсэн ерөнхий шаардлага тавьдаг, шүүгч, өмгөөлөгч гишүүд нэрээ дэвшүүлэн зөвлөлд ажиллах боломжтой. Зөвлөлийн дарга, гишүүдэд сар бүр мөнгөн урамшуулал олгох, урамшууллын хэмжээг Шүүхийн ерөнхий зөвлөл тогтоохоор зөвлөлийн дүрэмд заажээ.

Эдгээр зөвлөл, хороо нь харилцан адилгүй чиг үүргийг хэрэгжүүлдэг байх тул чиг үүргээс хамаарсан бүрэлдэхүүнтэй байх нь илүү тохиромжтой. Жишээлбэл, Өмгөөллийн мэргэшлийн хорооны нийт 9 гишүүний 7 гишүүнийг Өмгөөлөгчдийн Холбооноос (төлөөллийн 3 нь хуульч профессор) байхаар хуульчилсан нь өмгөөлөгчийн сонгон шалгаруулалт, үргэлжилсэн сургалт зохион байгуулах хорооны чиг үүргийг хэрэгжүүлэх чадавх бүхий бүрэлдэхүүнтэй байх шаардлагатайг харгалзан үзжээ гэж дүгнэж болох юм.

Иймд нотариатын мэргэшлийн хорооны дээрх бүрэлдэхүүнийг өөрчлөн нотариатын төлөөлөл дийлэнх олонх байхаар хуульчлах нь зүйтэй. Мэргэшлийн хорооны төлөөлөлд шүүхийн төлөөлөл 2 байхаар хуульчилсан нь шүүхийг төлөөлөн шүүхийн захиргааны ажилтан байх боломжтой гэж зарим талаар ойлголтын зөрүүтэй байдал үүсэхийг үгүйсгэхгүй бөгөөд Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ гэж, Шүүхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "шүүгч" гэж хуульд заасан үндэслэл, журмын дагуу томилогдож, шүүгчийн тангараг өргөсөн, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа Монгол Улсын иргэнийг гэж шүүхийг зөвхөн шүүгч төлөөлөх бүрэн эрхтэйг дурдаж байна.

Мөн Нотариатын мэргэшлийн шалгалттай холбоотой маргааныг⁴⁶ Захиргааны хэргийн анхан шатны шүүх харьяаллын дагуу хянан шийдвэрлэж байгаа тул шүүгчийг Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд оруулах нь мэргэшлийн хараат бус үйл ажиллагаанд нөлөөлөх талттай.

2.5. Зайн гэрчлэлтийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь

Манай улсад e-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн портал зэрэг цахим платформууд ашиглагдаж эхэлсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 499 дүгээр тогтоолоор дэвшилтэт технологи, олон улсын тэргүүн туршлагыг нэвтрүүлэх замаар "Цахим Үндэстэн" болох ажлыг дэмжин Төрийн цахим шилжилтийг хэрэгжүүлэх зорилготой Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох "Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар"-ыг байгуулсан нь "Төрийн цахим үйлчилгээний шат дамжлагыг бууруулж иргэдэд хүртээмжтэй хүргэн "Иргэн төвтэй нийгэм" байгуулахад

⁴⁴ Шүүхийн тухай хууль (2021)-ийн 71.1.16, 91.3 дахь хэсэг.

⁴⁵ Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Эвлэрүүлэн зуучлалын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх зар, <https://ubn.mn/p/32668>

⁴⁶ Нийцэх дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, Эх сурвалж Shuukh.mn

шаардлагатай цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөгжлийн тодорхой алхмууд мөн гэж үзэж болохоор байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 7.5-д Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадварыг бий болгоно гэж⁴⁷. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.3.5-д Бүх салбарын цахим шилжилтийн үйл ажиллагааг интеграцлагдсан кибер аюулгүй байдлын тогтолцоогоор хангана⁴⁸. Энэ хүрээнд төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг улсын хэмжээнд өргөжүүлнэ гэжээ. Төрийн болон бусад байгууллагын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжиж байгаатай холбогдуулан нотариатын үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэх зорилгоор нотариатын үйлдлийг цахимжуулах, улсын бүртгэлийн болон бусад холбогдох байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл дамжуулах, баяжуулах, харилцан мэдээлэл солилцох зохицуулалтыг бий болгох хэрэгцээ, шаардлага үүсэж байна.

Монголын Нотариатчдын Танхимын 2021-2025 оны стратеги төлөвлөгөөний Зорилт 1-д Дэвшилтэт техник, технологийг ашиглан хөгжлийн өндөр түвшинд хүрнэ. Танхимын гишүүд нь цаасан болон цахим системд суурилж, шуурхай, үйлчлүүлэгчийн эрэлт, хэрэгцээг ханган үйлчилнэ. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд 1/цахим нотариат системд бүрэн шилжих, 2/ цахим нотариат системийг өргөтгөх (өвийн программыг нэгтгэх, шинэ загвар боловсруулах, гэрээслэлийн бүртгэлийг бий болгох), 3/ орчин үеийн технологид суурилсан эрх зүйн үйлчилгээ үзүүлэх⁴⁹ гэж тусгасан байна.

Нотариатын болон бусад байгууллагын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжиж байгаатай холбогдуулан нотариатын үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэх зорилгоор нотариатын үйлдлийг цахимжуулах, улсын бүртгэлийн болон бусад холбогдох байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл дамжуулах, баяжуулах, харилцан мэдээлэл солилцох зохицуулалтыг бий болгох хэрэгцээ, шаардлага үүссэн⁵⁰ үнэлж, тус харилцааг Нотариатын тухай хуулийн 25¹ дугаар зүйлд Цахим үйл ажиллагаа эрхлэх гэж хуулиар нэмж зохицуулсан байна.

Юуны өмнө зайны болон дижитал нотариатын үйлчилгээг ялган авч үзэх шаардлагатай бөгөөд дижитал нотариат гэдэг нь биечлэн эсхүл онлайн уулзалт хийхгүйгээр зөвхөн электрон хэлбэрээр баталгаажуулсан баримт бичгийг үндэслэн нотариатын үйлдэл хийх хэлбэрийг ойлгох бол зайны нотариат гэдгийг аюулгүй холболтын хувьд баталгаажсан цахим эсхүл электрон шугамаар холбогдон зайны уулзалт зохион байгуулж, тухайн уулзалтын явцад хүний цахим баталгаажуулалтыг аливаа аргаар хангах замаар нотариатын үйлдлийг холын зайнаас хийж гүйцэтгэх хэлбэрийг ойлгохоор байна⁵¹. Хэдийгээр зайны болон дижитал нотариатын үйлчилгээнд биечлэн уулзах шаардлага ерөнхийдөө тавигдахгүй боловч тодорхой зарим тохиолдолд эсхүл тодорхой улс орны эрх зүйн зохицуулалтын хүрээнд нотариат дээр биечлэн очих шаардлагатай байхыг үгүйсгэх боломжгүй байна⁵².

⁴⁷ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын Хавсралт I

⁴⁸ Монгол Улсын Их Хурлын тогтоол, 2024.. Дугаар 21, Хавсралт I

⁴⁹ Монголын Нотариатчдын танхимын Бүх гишүүдийн хурлын тогтоол, 2021.. Дугаар 08

⁵⁰ Нотариатын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, Судалгааны тайлан, Уб., 2018, 292-294 дэх тал.

⁵¹ Notarycam, The Difference Between Electronic Notarization, Remote Notary, and Mobile Notary, 2023. Дэлгэрэнгүйг даарах холбооцооор хандаж үзэх боломжтой: <https://www.notarycam.com/difference-between-electronic-notarization-remote-notary-and-mobile-notary/>

⁵² Мөнгөнд

Нотариатын цахим үйл ажиллагааг 2012 оноос эхлэн судалж, Нотариатын тухай хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 25¹ дүгээр зүйлд Нотариатчийн цахим үйл ажиллагааг эрхлэх зохицуулалтыг нэмсэн. Тус зүйлд Танхим нь нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд нотариатын үйл ажиллагаатай холбогдох бүртгэл, мэдээллийн цахим санг бүрдүүлэх бөгөөд хуулиар хориглоогүй мэдээ, мэдээллийг улсын бүртгэл, татварын болон бусад холбогдох байгууллагад цахим хэлбэрээр дамжуулж, харилцан мэдээлэл солилцоно. Нотариатч нь гэрчилсэн үйлдэл бүрээр цахим бүртгэл хийх, мэдээлэл үүсгэх, санд байршуулах, баяжуулах, улсын бүртгэл, татварын болон холбогдох бусад байгууллагад дамжуулах, лавлагаа, мэдээлэл авах, зуучлах замаар нотариатын цахим үйл ажиллагаа эрхэлнэ. Эдгээр үйлчилгээг хэрэгжүүлэхтэй холбогдох үйл ажиллагааг “Нотариатын цахим мэдээллийн санд мэдээллийг хүлээн авах, хадгалах, ашиглах, түүний аюулгүй байдлыг хангах журам”⁵³-аар зохицуулж байна. Тус журамд нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй нотариатч бүртэй сангаас мэдээллийг хүлээн авах, хадгалах, ашиглах, түүний аюулгүй байдлыг хангах гэрээ байгуулан ажиллана гэжээ.

Нотариатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан Нотариатын үйл ажиллагааг нотариатч болон 16.2 (сумын Засаг даргын Тамгын газрын дарга, эсхүл тус газрын хуулийн мэргэжилтэн; тосгоны Захирагчийн ажлын албаны дарга), 16.3 (Хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газрын албан тушаалтан)-т заасан нотариатчийн үүрэг гүйцэтгэгчийн үзүүлсэн 1/нотариатаар гэрчлүүлсэн итгэмжлэлийн лавлагаа, 2/нотариатаар гэрчлүүлсэн тээврийн хэрэгслийн гэрээний лавлагаа, 3/нотариатаар гэрчлүүлсэн үйлдлийн архивын хуулбар авах, 4/нотариатын үйлдэл гэрчлүүлсэн эсэх лавлагаа, 5/хилийн чанадад суугаа нотариатчийн үүрэг гүйцэтгэгчээр гэрчлүүлсэн итгэмжлэлийн лавлагаа⁵⁴-г цахимаар олгож байна. Тухайлбал, Нотариатын цахим үйлчилгээг өргөжүүлэх хүрээнд Дипломат төлөөлөгчийн газарт гэрчлүүлсэн итгэмжлэлийг иргэд 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс хойш өөрт ойрхон байрлах нотариатчаас хүлээн авч Итгэмжлэлийн баруун буланд байрлах QR код, үсгэн кодыг нотариатчид хэлж баталгаажуулж авах⁵⁵ боломжтой болсон байна.

“Цахим нотариатын системийг ашиглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулж нотариатчийн үүрэг гүйцэтгэгч нарыг нотариатын цахим системд бүрэн холбох⁵⁶ ажлыг үргэжлүүлж байгаа аж. Нотариатчдын Танхимаас урт хугацаандаа Зайн гэрчлэлтийн үйлчилгээг нэвтрүүлэх хүрээнд гадаадын зарим улсын зайны нотариатын үйлдэл хийхэд тавигдаж буй шаардлага болон бусад хүчин зүйлийн талаар харьцуулалт хийснийг танилцуулж байна. Гэвч энэ нь нотариатын үйлдлийг цахимаар гүйцэтгэж байгаа хэлбэр биш зөвхөн нотариатын үйл ажиллагаанд шаардлагатай цахим системийг хөгжүүлж байгаа хэлбэр юм.

Франц Улсад зайны нотариатын үйлдэл хийхэд харьцангуй сүүлийн үеийн эсхүл хамгийн сүүлийн үеийн ширээний эсхүл зөөврийн компьютер, цахим гарын үсэг эсхүл цахим тамгатай байх зэрэг тодорхой шаардлагуудыг тавьдаг. Үүнээс гадна тус улсад зайны нотариатын үйлдлийг IDnow гэх тусгай платформоор дамжуулан хийх бөгөөд нийтлэг

⁵³ Нотариатын цахим мэдээллийн санд мэдээллийг хүлээн авах, хадгалах, ашиглах, түүний аюулгүй байдлыг хангах журам. Хууль зүйн сайдын тушаал. 2020.. Дугаар А/01.

⁵⁴ Цахим үйлчилгээний нэгдсэн портал: <https://e-mongolia.mn/services/citizen/sector/646597f28c629b783b14fd16>

⁵⁵ Гадаад харилцааны яамны Консулын газрын албан ёсны вебсайт. <https://www.consul.mn/services>

⁵⁶ Монголын Нотариатчдын танхимын тайлан 2024.

хэрэглээний Skype, Zoom, WhatsApp, FaceTime гэх мэт программ ашиглахыг хатуу хориглодог ажээ⁵⁷. Франц Улстай харьцуулан үзвэл манай улсад цахим гарын үсэг болон тамгыг эрсдэлгүй ашиглах боломж бүрэн бүрдээгүй, өндөр хурдны интернэт холболт төдийлөн хүртээмжтэй бус байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2020 онд бэлтгэн гаргасан Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд "... Төрийн үйлчилгээ, харилцааг цахим хэлбэрээр явуулах, цахим болон тоон гарын үсгийн хэрэглээ хангалттай биш байгаа өнөөгийн байдал нь Монгол Улсын засаглалын чадавхи болон цахим засгийн хөгжлөөр бусад орнуудаас хоцрох нөхцөлийг бүрдүүлж байна ... "цахим тамга гэж эцсийн байдлаар гарал үүсэл болон бүрдлийг батлах цахим хэлбэрийн өгөгдөлд хавсаргасан эсвэл логик хамааралтай цахим өгөгдлийг хэлнэ" хэмээн заасны дагуу цахим тамганы зохицуулалтыг хуульчлах ..." шаардлагатай гэж дүгнэсэн⁵⁸ бол Нээлттэй нийгэм форумаас 2020 онд гаргасан "Боловсролын салбарт коронавируст цар тахлын үзүүлж буй нөлөөлөл цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүртээмж, үр дүн, нөлөөлөгч хүчин зүйлс" судалгаанд "... Интернэт хэрэглэгчдийг байршлаар нь авч үзвэл, хотын хүн амын 72.4, орон нутгийн хүн амын 49.3 хувь нь тус тус интернэт хэрэглэж байна" гэж дүгнэсэн байна⁵⁹.

Эстони Улсад зайны гэрчлэлт гүйцэтгэхийг Нотариатын үйл ажиллагааны тухай хуулиар⁶⁰ зөвшөөрсөн бөгөөд нотариатч болон хэлцэлд оролцогчид нотариатын баримт бичигт тоон гарын үсэг зурж баталгаажуулах, хэлцэлд холбогдох аливаа баримт бичгийн цахим хуулбарыг ямар эх сурвалжаас, ямар дарааллаар хэрхэн баталгаажуулсныг нотариатчийн тэмдэглэлд тодорхой тусгах зэрэг нарийвчилсан зохицуулалтуудыг тус хуульд заасан байна. Түүнчлэн тус улсын Цахим гарын үсгийн тухай 2000 оны хууль⁶¹, Европын Холбооны Европын парламентаас 2014 онд баталсан Дотоодын зах зээл дэх цахим гүйлгээний цахим таних, цахим итгэлцлийн үйлчилгээний No 910/2014 удирдамжид заасан шаардлагууд зэрэг холбогдох аюулгүй байдлын стандартуудыг дагаж мөрдөх зайлшгүй шаардлагатай байна. Эстони Улстай харьцуулж үзвэл манай улсын хувьд нотариатын үйлдлийг зайнаас баталгаажуулах дэс дараалал, тодорхой шаардлагуудыг тусгасан дүрэм, журам, тэдгээрт баримтлах шаардлагыг тусгасан аюулгүй байдлыг хангах, цахимаар таних, цахим итгэлцэл үүсгэх тухай стандартууд төдийлөн хангалтгүй, зайны болон дижитал нотариатын үйлдлийг гүйцэтгэх урьдач нөхцөл хараахан бүрдээгүй гэж үзэж болохоор байна. Ялангуяа зайн нотариатын үйлдлийг гүйцэтгэхэд тухайн этгээд цахим төхөөрөмжийг өөрөө ашиглаж байгааг тодруулах зорилгоор дуу-дүрсний аливаа тасалдалгүй холболт заавал шаардлагатай тул өндөр хурдтай интернэтийн шаардлагатай, дижитал нотариатын хувьд цахим, гарын үсэг, цахим тамгын баталгаажуулалт зайлшгүй шаардлагатай юм.

⁵⁷ Францын нотариатын албан ёсны вебсайт, Power of attorney at the notary: how to sign online?, 2025 онь Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой: <https://www.notaires.fr/en/notarial-profession/role-notaries-and-his-principal-activities/power-attorney-notary-how-sign-online>

⁵⁸ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 2020., 45 дахь тал.

⁵⁹ Нээлттэй нийгэм форум, Эрдэм сургалт судалгааны хүрээлэн, Боловсролын салбарт коронавируст цар тахлын үзүүлж буй нөлөөлөл цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүртээмж, үр дүн, нөлөөлөгч хүчин зүйлс, 2020., 74 дэх тал

⁶⁰ Тус хуулийн 13, 38-43 дугаар зүйл.

⁶¹ Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой: <https://www.riigiteataja.ee/en/eli/530102013080/consolide>

ХБНГУ-ын хувьд нотариатын зайны нотариатын үйлчилгээг онлайн хэлбэрээр зөвхөн Германы Холбооны Нотариатчдын танхимын албан ёсны вебсайт дахь <https://online.notar.de/> веб хуудсаар дамжуулан хийж болох бөгөөд онлайн нотариатын үйл ажиллагаанд мэдээллийн хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдлын хамгийн өндөр шаардлагыг хангаж, мэдээллийн нууцлалыг нотариатчтай биечлэн уулзаж байгаатай адил хэмжээнд баталгаажуулах найдвартай холболтыг ашиглаж байгаа гэж үздэг байна⁶². Нотариатын онлайн процедурыг Германы Холбооны Нотариатчдын танхим удирдан хариуцдаг. Герман болон Франц улсын зайны нотариатын туршлагаас зайны нотариатын үйлчилгээнд маш өндөр нууцлал, баталгаажуулалтыг хангасан тодорхой нэг л шугамаар зайнаас нотариатын үйлдэл гүйцэтгэх боломжтой бөгөөд нийтлэг програмуудыг ашиглахаас татгалздаг байна.

Сингапур Улсын хувьд интернэтийн хурдыг улс орон даяар 10 Gbps буюу 1 секундэд 10 гигабайт хүргэх төлөвлөгөөт ажлыг 2024 оны 2 дугаар сард эхлүүлсэн⁶³ бөгөөд энэ ажилд 100 сая сингапур долларын буцалтгүй тусламж олгосон. Түүнчлэн нотариатын үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэх чиг үүрэгтэй Сингапурын хуулийн академиас тус улсын Дижитал хөгжил, мэдээллийн яамны харьяа Сингапурын хууль ёсны зөвлөл болох Infocomm Media Development Authority-тай хамтран баримт бичгийн баталгаажуулалтын үр ашиг, аюулгүй бөгөөд найдвартай байдлыг сайжруулахад чиглэгдсэн апостиль баталгаажуулах үйл ажиллагаанд танин баталгаажуулах шинэ технологийг нэвтрүүлснээр 2025 оноос эхлэн дижитал нотариатын үйлчилгээг маш хурдан бөгөөд баталгаатай гүйцэтгэх боломжтой болсон байна⁶⁴.

Дижитал нотариатын үйл ажиллагаандаа Сингапур Улс нь World Wide Web Consortium (W3C) болон Танин Баталгаажуулалт (VC) зэрэг өндөр зэрэглэлийн технологи ашиглан зөвхөн улс дотроо ч бус олон улсын тогтолцоо, практикт нийцсэн шийдлийг бий болгосон анхны улс гэж үзэж байгаа ажээ⁶⁵. Сингапур Улсын туршлагыг судалж үзвэл танин баталгаажуулах сүүлийн үеийн найдвартай, технологи, өндөр хурдны интернэтийн дэд бүтцийг ашиглан төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд зайны нотариатын хамгийн сүүлийн үеийн үйлчилгээг нэвтрүүлжээ.

Хүснэгт 5. Дэлхийн 154 улсын интернэтийн дундаж таталтын хурд (2025 оны 3 дугаар сарын байдлаар)⁶⁶

Эрэмб ы	Улс / Бүс нутаг	Таталтын дундаж хурд (mbit/s)
1	Сингапур	357.52
2	Арабын Нэгдсэн Эмират	321.3
3	Хонг Конг	313.9
4	Франц	301.65
5	Исланд	300.42

⁶² Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой: <https://online.notar.de/en/help-faq/general-information/official-portal-for-online-notary-appointments>

⁶³ Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой: <https://www.imda.gov.sg/how-we-can-help/10g-nbn-grant>

⁶⁴ Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой: <https://www.imda.gov.sg/resources/press-releases-factsheets-and-speeches/press-releases/2024/announcement-of-e-apostille-and-gpt-legal>

⁶⁵ Мон тэнд.

⁶⁶ Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой: <https://www.speedtest.net/global-index#mobile>
Speedtest Global Index – Internet Speed around the world

6	Америк	287.47
7	Чили	282.66
8	Дани	270.41
9	Хятад	261.53
10	Швейцар	251.78
55	Герман	99.19
66	Эстони	92.98
89	Монгол	76.33

Энэхүү өгөгдлийн хүрээг 154 улсаар хязгаарлаж, интернэтийн дундаж таталтын хурдны үзүүлэлтэд Сингапур Улс тэргүүлж байгаа нь энэ төрлийн үйлчилгээний найдвартай байдлын нэг чухал үзүүлэлт гэж үнэлж байна. Мөн туршлага болгон судалсан Франц-4, Герман-55, Эстони-66, Монгол Улсын хувьд 89-д эрэмбэлэгджээ.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 5.3-т Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ. **I үе шат (2021-2030):** Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлэх үе. 1) Цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж, хүн амыг өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбоно. 2) Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болж хөгжинө. 3) Цахим хэлбэрт шилжсэнээр цаг хугацаа, орон зайнаас үл хамааран төрийн үйлчилгээ шат дамжлагагүй, шуурхай болно⁶⁷ гэж тусгасан. Энэ нь интернэтийн сүүлийн үеийн технологи, өндөр хурдны интернэтийн дэд бүтцийг бий болгож, гадаад улсаас дижитал нотариатын үйлчилгээг хэрэглэхээр ажиллаж буйг илэрхийлж байна. Хэдийгээр өнөөдөр ч гадаад улсаас нотариатын зарим үйлчилгээг авч болж байгаа ч дэд бүтцийн хувьд зайн гэрчлэлт хийх боломжийг нэмэгдүүлж дэд бүтэц хөгжөөгүй, алслагдмал орон нутагт 50 орчим хувь нь интернэт тогтмол хэрэглэдэггүй, хөгжлийн бэрхшээл болон насны ялгаатай байдлаас шалтгаалан тухайн этгээд өөрөө цахим төхөөрөмжийг ашиглаж байгаа эсэхэд эргэлзээ үүсэх учир дуу-дүрсний тасалдалгүй холболтоор дамжуулж заавал давхар баталгаажуулах шаардлагатай. Иймд зөвхөн өндөр хурдны интернэттэй хүн ам төвлөрсөн газар нутагт зайн гэрчлэлтийг туршин хэрэгжүүлж, хөгжүүлж эхлэх нь зөв гэж үзэж байна.

Хүснэгт 6. Нийт идэвхтэй хэрэглэгчийн тоо (Баян-Өлгий, Дорнод)⁶⁸

Аймаг,хот	№	Байршил	Суурин интернэт хэрэглэгчийн тоо
			ISP
НИЙТ ДҮН			465,486
УЛААНБААТАР ХОТЫН НИЙТ ДҮН			348,191
АЙМГУУД үүнээс:			117,295

⁶⁷ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого.. Улсын Их Хурлын тогтоол, 2020.. Дугаар 52. Хавсралт I

⁶⁸ Хариуцаа холбооны зохицуулах хороо, Нийт идэвхтэй хэрэглэгчийн тоо (байршилаар) 2023 хагас жил.

БАЯН-ӨЛГIIЙ АЙМАГ	БАЯН-ӨЛГIIЙ	1	Алтай	11
	БАЯН-ӨЛГIIЙ	2	Алтанцөгц	36
	БАЯН-ӨЛГIIЙ	3	Баяннуур	21
	БАЯН-ӨЛГIIЙ	4	Бугат	5
	БАЯН-ӨЛГIIЙ	5	Булган	60
	БАЯН-ӨЛГIIЙ	6	Буюнт	3
	БАЯН-ӨЛГIIЙ	7	Дэлүүн	26
	БАЯН-ӨЛГIIЙ	8	Ногооннуур	6
	БАЯН-ӨЛГIIЙ	9	Өлгий	2,878
	БАЯН-ӨЛГIIЙ	10	Сагсай	32
	БАЯН-ӨЛГIIЙ	11	Толбо	3
	БАЯН-ӨЛГIIЙ	12	Улаанхус	19
	БАЯН-ӨЛГIIЙ	13	Цэнгэл	7
	БАЯН-ӨЛГIIЙ	Нийт дүн		3,107
ДОРНОД АЙМАГ	ДОРНОД	1	Баяндүн	93
	ДОРНОД	2	Баянтүмэн	4
	ДОРНОД	3	Баян-Уул	52
	ДОРНОД	4	Булган	38
	ДОРНОД	5	Гурванзагал	2
	ДОРНОД	6	Дашбалбар	4
	ДОРНОД	7	Матад	36
	ДОРНОД	8	Сэргэлэн	6
	ДОРНОД	9	Халхгол	144
	ДОРНОД	10	Хөлөнбуйр	11
	ДОРНОД	11	Хэрлэн	1,588
	ДОРНОД	12	Цагаан-Овоо	7
	ДОРНОД	13	Чойбалсан	5,060
	ДОРНОД	14	Чулуунхороот	3
	ДОРНОД	Нийт дүн		7,048

Дээрх суурин интернэт хэрэглэгчийн тоон үзүүлэлт нь зайн гэрчлэлтийн талаарх дүгнэлттэй уялдаж буйг дурдах нь зүйтэй.

Эрх зүйн зохицуулалтын хувьд Монгол Улсын Иргэний хуулийн 42¹ дүгээр зүйлд “Хуульд зааснаар бүртгүүлэх, нотариатаар гэрчлүүлбэл зохих болон бичгээр хийхээр заасан хэлцлийг цахим хэлбэрээр хийж болно” гэж заасан бөгөөд Цахим гарын үсгийн тухай хууль (2021)-д цахим орчинд хүн, хуулийн этгээд цахим гарын үсэг хэрэглэх, түүнд тавигдах эрх зүйн болон техникийн шаардлага, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон зэрэг нь манай улсад зайн гэрчлэлтийг явуулах эрх зүйн үндэслэл бүрдсэн байгаа гэж ойлгож болохоор байна. Түүнчлэн нийгмийн хөгжлийн хувьд цахим зээл олгох үйл явц бодит амьдралд нийтлэг байгаа зэрэг нь дижитал болон зайны гэрчлэлт хийх нийгмийн шаардлага бий болсныг харуулж байна.

Эдгээрээс манай улсад зайн гэрчлэлтийг хөгжүүлэн хэрэглэх нийгмийн шаардлага үүссэн, техник, технологийн хувьд хурдацтай хөгжиж байгаа зэрэг нь нотариатын үйлдлийг зайнаас баталгаажуулах боломжийг нэмэгдүүлж байна гэж үзэх үндэслэлтэй юм. Монгол Улс нь зайн гэрчлэлтийн нотариатын үйлчилгээг хуульчилсан тохиолдолд тус үйлчилгээнээс үүсч болзошгүй эрсдлийг үнэлж, урьдчилан сэргийлэх, цахим үйлчилгээний аюулгүй найдвартай байдлыг хангаж ажиллах шаардлагатай юм. Түүнчлэн зайн гэрчлэлтийн цахим болон дижитал аль аль хувилбаруудыг нарийвчлан зохицуулсан журам урьдчилан батлахгүйгээр зайн

гэрчлэлтийг эхлүүлэх нь эрсдэлтэй. Учир нь үйлчлүүлэгчийг баталгаажуулах цахим гарын үсэг, цахим тамга зэргийн нууцлал, түүнийг танин баталгаажуулах технологийн аюулгүй байдал зэргийг маш өндөр түвшинд хангаж, байнга сайжруулж байхгүй бол кибер болон бусад хэлбэрийн халдлагын эрсдэл харьцангуй өндөр юм. Гэвч дотоодын нөхцөл боломжид тулгуурлан зайн болон дижитал гэрчлэлт нэвтрүүлэхэд урьдчилан бэлтгэж, тодорхой хувилбаруудыг туршиж байх нь зүйтэй бөгөөд эдгээр нь цаашид зайн гэрчлэлтийн нотариатын үйлчилгээг бүрэн нэвтрүүлэхэд давуу талтай юм.

2.6. Нотариатын мэдэгдэх хуудас, түүний ач холбогдол

Нотариатын мэдэгдэх хуудсыг Нотариатын тухай хууль (2011)-ийн 25 дугаар зүйлд заасан нотариатын үйлдлийн төрөлд нэмж хуульчилсан.

Нотариатын тухай хуулийн 45 дугаар зүйлд талууд үл маргах журмаар төлбөрийг төлөх, үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс гаргуулахаар харилцан тохиролцож байгуулсан нотариатаар батлагдсан гэрээ, төлбөрийг нотолсон баримт бичгийг үндэслэн төлбөр төлөгчөөс мөнгө, эдийн болон эдийн бус хөрөнгийг гаргуулахаар төлбөр авагчийн хүсэлтээр нотариатч мэдэгдэх хуудас үйлдэнэ.

Шигтгээ 6.

Нотариатчийн мэдэгдэх хуудас нь маш энгийн бөгөөд цаг хугацаа, зардал хэмнэсэн баримт бичиг байдаг. Мон практикт бичээд хэвшвэл шүүхийн ачааллыг бууруулах ач холбогдолтой. Танхимын зүгээс 2023 онд МХХ-ны Нотариатчдын хөгжлийг дэмжих хорооноос санаачлан мэдэгдэх хуудсыг бичих үйлдлийг практикт хэвшүүтэх, шүүхийн ачааллыг бууруулах, хууль хэрэглээний нэгдмэл ойлголттой болох талаар хэлэлцүүлэг болон сургалт зохион байгуулсан. 2024 оны байдлаар 280 гаруй нотариатчийн мэдэгдэх хуудас бичиж шүүхэд баталгаажуулахаар хүргүүлсэн байна. Тэгэхээр нотариатын мэдэгдэх хуудас бичих үйлдэл нь түгээмэл гэж үзэж болохгүй юм.

Нотариатчтай хийсэн ярилцлагаас...

Хүснэгт 7. Мэдэгдэх хуудас бичих эрх зүйн үндэслэл

Хууль, хэм хэмжээний акт	Мэдэгдэх хуудас бичих үндэслэл
	25 дугаар зүйл. Нотариатын үйлдлийн төрөл 25.1.12.нотариатын мэдэгдэх хуудас бичих.
Нотариатын тухай	45 дугаар зүйл.Нотариатчийн мэдэгдэх хуудас, түүний агуулга 45.1.Талууд үл маргах журмаар төлбөрийг төлөх, үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс гаргуулахаар харилцан тохиролцож байгуулсан нотариатаар батлагдсан гэрээ, төлбөрийг нотолсон баримт бичгийг үндэслэн төлбөр төлөгчөөс мөнгө, эдийн болон эдийн бус хөрөнгийг гаргуулахаар төлбөр авагчийн хүсэлтээр нотариатч мэдэгдэх хуудас үйлдэнэ. 45.2.Энэ хуулийн 45.1-д заасан мэдэгдэх хуудас үйлдэхдээ нотариатч дараахь нөхцөлийг харгалзана: 45.2.1.баримт бичиг нь төлбөр төлөгчөөс төлбөр авагчид төлбөр төлөх нь маргаангүй гэдгийг нотолж байгаа эсэх; 45.2.2.нэхэмжлэл гаргах эрх үүсвэргээс хойш гурван жилийн хугацаа өнгөрсөн эсэх. 45.3.Нотариатчийн мэдэгдэх хуудсанд дараахь зүйлийг заана: 45.3.1.мэдэгдэх хуудас олгож байгаа нотариатчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, харьяалах тойрог; 45.3.2.ямар баримт бичгийг үндэслэж мэдэгдэх хуудас үйлдэж байгаа; 45.3.3.төлбөр авагч, төлбөр төлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, ажлын болон оршин суугаа газрын хаяг, аж ахуйн нэгж, байгууллагын оноосон нэр, үйл ажиллагаа явуулж байгаа газрын хаяг, банкн дахь харилцах дансны дугаар, улсын бүртгэлийн дугаар; 45.3.4.төлбөр гаргуулах хугацаа; 45.3.5.төлбөрийн хэмжээ, шаардлагын зүйл, хэрэв мэдэгдэх хуудас үйлдэхэд үндэс болгосон баримт бичигт заасан бол хүү, нэмэгдүүлсэн хүү, анзын хэмжээ; 45.3.6.нотариатын үйлчилгээний хөлс, зардлын хэмжээ;

	45.3.7.мэдэгдэх хуудас үйлдсэн он, сар, өдөр, дугаар. 45.4.Нотариатч мэдэгдэх хуудсыг хэвлэмэл хуудас дээр үйлдэж, тамга дарж, гарын үсэг зурна. 45.5.Нотариатчийн мэдэгдэх хуудсанд заасан төлбөрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу гаргуулна.
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай	184.3.Цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хоронгийн харилцаага хүлээлгэх тухай тушаал, Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, Арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, улсын байцаагчийн төлбөр тогтоосон актыг биелүүлэх боломжийг нь шүүх хянан үзэж ирүүлсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүгчийн захирамжаар баталгаажуулна. Шүүгч ийнхүү захирамж гаргасан даруй гүйцэтгэх хуудас бичиж 7 хоногийн дотор төлбөр авагч, төлбөр төлөгч, шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлнэ.
Нотариатын үйлдэл хийх заавар ⁶⁹	Арван тав. Нотариатчийн мэдэгдэх хуудас бичих 15.1.Нотариатч мэдэгдэх хуудас үйлдэхдээ Нотариатын тухай хуулийн 45 дугаар зүйлийг баримтална. 15.2.Нотариатч нь зөвхөн эрх бүхий байгууллагаас баталсан мэдэгдэх хуудасны загварын маягтыг хэрэглэнэ. 15.3.Нотариатч мэдэгдэх хуудсыг төлбөр авагч болон түүний төлөөлөгчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн олгоно. 15.4.Талуудын хооронд төлбөрийг нотолж бичгээр хийсэн хэлцэл болон төлбөрийг үл маргах журмаар биелүүлэхээр тохиролцож нотариатаар гэрчлүүлсэн гэрээг тус тус үндэслэн нотариатч мэдэгдэх хуудас бичнэ. 15.5.Мэдэгдэх хуудас бичихдээ үндэслэн баримт бичгийн эх хувийг нотариатч өөртөө авч үлдэнэ. Мэдэгдэх хуудсанд хавсаргасан хуулбар, баримтуудын хуудас бүр дээр тамга дарна. 15.6.Нотариатчийн мэдэгдэх хуудас нь хэвлэмэл байна. Мэдэгдэх хуудсанд нотариатч тамгаа дарж, гарын үсэг зурна. 15.7.Ирүүлсэн баримт бичгийг үндэслэн мэдэгдэх хуудас бичих бололцоогүй тохиолдолд нотариатч энэ тухай үндэслэлээ хүсэлт гаргасан этгээдэд тодорхой тайлбарлаж баримт бичгийг буцаана. 15.8.Мэдэгдэх хуудсыг тусад нь бүртгэлийн дэвтэрт бүртгэж, хүтээн авсан хүнээр гарын үсэг зуруулна. 15.9.Бүртгэлийн дэвтэрт хүсэлт гаргасан этгээд/төлбөр авагч/ болон төлбөр төлөгчийн овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, бичиг баримт/иргэний үнэмлэх, гэрчилгээ/-ын дугаар, регистр, аж ахуйн нэгж, байгууллагын оноосон нэр, хаяг, бүртгэлийн дугаар, төлбөрийн агуулга, хэмжээ, мэдэгдэх хуудас бичсэн он, сар, өдөр, дугаар, үйлчилгээний хөлс зэргийг тодорхой тэмдэглэнэ⁷⁰.
Нотариатын үйлчилгээний хөлс, зардал ⁷¹	Тодорхой үнийн дүн, төлбөрийн хэмжээ бүхий бүх төрлийн гэрээ, хэлцлийг гэрчлэх, Нотариатчийн мэдэгдэх хуудас бичих⁷² • 1 сая тогрог хүртэл бол үнийн дүнгийн 0.5 хувиар • 1 сая тогрогөөс дээш бол шатлалаар

Нотариатын мэдэгдэх хуудас бичих үйлдлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183 дугаар зүйл, 184 дүгээр зүйл, Нотариатын тухай хуулийн 25, 45 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 10 дугаар зүйл, Нотариатын үйлдэл эрхлэн хийх зааврын 15 дугаар зүйлээр тус тус зохицуулсан байна. Мөн нотариатын үйлчилгээний хөлс, зардал тогтоосон ХЗДХСайдын тушаалд нэмэлт оруулжээ.

Төлбөр авагчийн хүсэлтээр нотариатаар гэрчлүүлсэн гэрээ, төлбөрийг нотолсон баримт бичгийг үндэслэн нотариатч мэдэгдэх хуудас бичдэг. Талуудын хооронд ямар нэгэн маргаангүй, төлбөр төлөгч нь төлбөр төлөхөө хүлээн зөвшөөрсөн энэ тухайгаа гэрээ байгуулж гэрчлүүлсэн байхыг шаарддаг. Түүнчлэн мэдэгдэх хуудас бичихдээ баримт бичиг, гэрээ нь төлбөр төлөгчөөс төлбөр авагчид төлбөр төлөх нь маргаангүй гэдгийг нотолж байгаа эсэх,

⁶⁹ Нотариатын үйлдэл хийх заавар. Хууль зүйн сайдын тушаал. 2011.. Дугаар 171. Хавсралт IV.

⁷⁰ Нотариатын үйлдэл хийх заавар. ХЗДХСайдын тушаал. 2021.. Дугаар А/210 (өөрчилсөн).

⁷¹ Нотариатын үйлчилгээний хөлс, зардал. Хууль зүйн сайдын тушаал. 2011.. Дугаар 123.

⁷² "Нотариатчийн мэдэгдэх хуудас бичих" гэснийг ХЗДХСайдын тушаал. 2023.. Дугаар А/348 (нэмсэн).

нэхэмжлэл гаргах эрх үүссэнээс хойш 3 жил өнгөрсөн эсэх нөхцөлийг харгалзан үздэг байна. Мэдэгдэх хуудсанд заасан үүргийг биелүүлэх хугацааг зааж өгснөөр төлбөр төлөгчид төлбөр төлөх боломжит хугацааг олгодог давуу талтай⁷³. Тус хугацаа нь мэдэгдэх хуудсанд заасан үүргийг сайн дураар биелүүлэх хугацаа бөгөөд хугацаандаа үүргээ биелүүлээгүй бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002)-д зааснаар төлбөр төлөгчийн оршин суугаа газрын шүүхэд төлбөр авагч нь хүсэлт гаргаж нотариатчийн мэдэгдэх хуудас, холбогдох гэрээ, баримт бичгийг хавсаргаж өгнө. Шүүх хүлээн авч Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлийн 184.3-т заасны дагуу шүүгчийн захирамж гарган баталгаажуулна. Шүүх захирамж гаргасан даруйдаа гүйцэтгэх хуудас бичиж Шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд заасны дагуу уг мэдэгдэх хуудсыг албадан гүйцэтгүүлнэ гэсэн хуулийн зохицуулалттай.

Шигтгээ 7.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлийн 184.3-д “Цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хоронгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, Арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, улсын байцаагчийн төлбөр тогтоосон актыг биелүүлэх боломжийг нь шүүх хянан үзэж ирүүлсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүгчийн захирамжаар баталгаажуулна. Шүүгч ийнхүү захирамж гаргасан даруй гүйцэтгэх хуудас бичиж 7 хоногийн дотор төлбөр авагч, төлбөр төлөгч, шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлнэ” гэж заасан. Гэтэл нотариатчийн бичсэн мэдэгдэх хуудсыг шүүх баталгаажуулсан эсэх, мөн баталгаажуулаагүй бол ямар үндэслэлээр баталгаажуулаагүй вэ гэдгийг мэдэх боломж байдаггүй. Учир нь ИХШХШТХ-д ямар үндэслэлээр нотариатын мэдэгдэх хуудсыг баталгаажуулахаас татгалзах үндэслэлийг хуульчилж өгөөгүй. Энэ нь ойлгомжгүй байдлыг үүсгэж алдаагаа засах боломжийг олгодоггүй /засах боломжтой алдаа байж болно/. Мөн бичсэн мэдэгдэх хуудсаа баталгаажсан эсэхийг мэдэх эргэх холбоо байдаггүй.

Нотариатчтай хийсэн ярилцлагаас...

Нотариатын мэдэгдэх хуудсыг 2021 онд 32, 2022 онд 72, 2023 онд 213⁷⁴, 2024 онд 155⁷⁵ бичжээ. Энэхүү тоон судалгаанаас харахад нотариатын мэдэгдэх хуудас бичих үйлдлийн талаарх үйлчлүүлэгчдийн мэдлэг, ойлголт дутмаг, тухайн үйлдлийн эрх зүйн үр дагавар, хууль зүйн ач холбогдлыг тайлбарлаж зөвлөгөө өгөх зэрэг хуульд заасан үүргээ зөвшөөрөл бүхий этгээд биелүүлэхэд цаг хугацаа, үйлчилгээний хөлс, шүүх хүлээн авч баталгаажуулж буй туршлага, хүлээн авахаас татгалзаж буй үндэслэл эргэх холбоо зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг байна.

МХХ-ны Нотариатчдын хөгжлийг дэмжих хорооноос санаачлан холбогдох байгууллагуудтай хамтран “Нотариатын мэдэгдэх хуудас шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл болох нь”⁷⁶ сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж, Монголын Нотариатчдын Танхим, Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандсан санал, зөвлөмжийг гаргасан байна.

Бүгд Найрамдах Франц Улсын Иргэний хуулийн⁷⁷ 1369 дүгээр зүйлд “Гэрчилсэн баримт бичиг (authenticated instrument) нь түүнийг шаардлагатай хэлбэрээр бэлтгэн боловсруулсны үндсэн дээр бүрэн эрх, чиг үүрэг бүхий төрийн албан хаагчийн хүлээн авч баталгаажуулсан баримт бичиг юм. Гэрчилсэн баримт бичгийг Захиргааны хэргийн дээд зөвлөл (Conseil

⁷³ Ч.Баянжаргал (2024). Гэрээний биелэлтийг хялбараар шийдвэрлэх нь... <https://ikon.mn/n/33s3>

⁷⁴ Монголын Нотариатчдын танхимын тайлан 2023, 2024.

⁷⁵ Эх сурвалж: Цахим нотариат систем.

⁷⁶ Нотариатын мэдэгдэх хуудас бичих, баталгаажуулахтай холбоотой санал, зөвлөмж, МХХ-ны Ерөнхийлөгчийн албан бичиг, 2024.1.18-ны өдөр.

⁷⁷ Бүгд Найрамдах Франц Улсын Иргэний хуулийн англи хэл дээрх хувилбарыг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой: https://www.trans-lex.org/601101/_french-civil-code-2016/

d'État)-ийн тогтоолоор тусгайлан тогтоосон нөхцөлийг ханган байгуулж, хадгалах тохиолдолд цахим хэрэглүүрээр дамжуулан байгуулж болно. Нотариатч нь ийм баримт бичгийг хүлээн авч баталгаажуулах бол хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд гэрчилсэн баримт бичгийг өөрийн гараар мэдүүлэн бичих шаардлагагүй” гэж заасан байна. Түүнчлэн Франц улсын Нотариатчдын танхимын албан ёсны вебсайтад нотариатын гэрчилсэн баримт бичгийг тодорхойлохдоо гэрээслэл, гэрлэлтийн гэрээ, бэлэглэлийн гэрээ болон үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ зэрэг тодорхой гэрээг нотариатаар заавал гэрчлүүлэх бөгөөд бусад зарим тохиолдолд гарын үсэг зурсан үйл баримтыг батлан гэрчлүүлэх чиг үүрэг шаардлагатай бол нотариатын үйлчилгээ авч болно гэж тодорхойлсон бол “Хүчин чадал ба үр нөлөө” гэсэн хэсэгт төлбөр төлөгч нь мөнгөн төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд Гэрчилсэн баримт бичигт үндэслэн зээлдүүлэгч нь шүүхээр шийдвэрлүүлэхгүйгээр төлбөрөө авах үндэслэл болох бөгөөд Гэрчилсэн баримт бичгийг шүүхийн шийдвэрийн адил гүйцэтгүүлэх боломжтой гэж дурджээ. Гэвч энэ нь зөвхөн ерөнхий мэдээлэл байх бөгөөд Франц Улсын Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны тухай 2012 оны хууль (French Code of Civil Enforcement Procedures 2012)-ийн L. 111-3 дугаар зүйлд зөвхөн дараах баримт бичгүүдийг шүүхийн шийдвэрийн адил гүйцэтгэнэ гэж заасан бөгөөд тус зүйлийн 4-т “үүрэг гүйцэтгэх тухай заалт бүхий нотариатаар батлуулсан хэлцэл, гэрлэгч хоёр тал зөвшөөрснийг хоёр талын өмгөөлөгчдийн гарын үсэг зурж баталгаажуулан Иргэний хуулийн 229-1 дүгээр зүйлд заасны дагуу гүйцэтгүүлэх хүсэлт гарган нотариатад хүргүүлсэн гэрлэлт цуцлалтын баримт бичиг” гэж тодорхой заасан байна.

Эдгээрээс дүгнэж үзвэл Франц Улсын хуулийн дагуу “үүрэг гүйцэтгэх тухай заалт” буюу “enforcement clause” тусгайлан оруулсныг нотариатаар гэрчлүүлсэн тохиолдолд манай улсад мөрдөгдөж байгаа “мэдэгдэх хуудас”-ын зохицуулалтын адил гүйцэтгүүлэх, түүнчлэн гэрлэлт цуцлалтын баримт бичигт тусгай үйл явц, шаардлагад нийцүүлэн нотариатаар гэрчлүүлсэн тохиолдолд шүүхийн шийдвэрийн адил гүйцэтгүүлэх зохицуулалттай байна.

2.7. Нотариатчид сахилгын шийтгэл оногдуулах хугацаа, сахилгын шийтгэлийн төрөл

Монголын Нотариатчдын Танхимын 2021-2025 оны стратеги төлөвлөгөөний Зорилт 3-т Нотариатч ёс зүйтэй ажиллана. Нотариатч нь хуульчийн⁷⁸ болон нотариатчийн ёс зүйг⁷⁹ чанд сахин үйл ажиллагаа явуулна. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд 3/ мэргэшлийн ёс зүйн хэм хэмжээг үндэслэн Нотариатын тухай хуульд заасан сахилгын арга хэмжээг боловсронгуй болгох⁸⁰ гэжээ.


Нотариатчид хүлээлгэх сахилгын хариуцлагыг ёс зүйн болон эрх зүйн хэм хэмжээний ангиллаар зааглан, түүнд тохирсон шинэтгэлийн төрлийг тогтоож, мэргэжлийн хариуцлагын даатгал буюу түүнтэй дүйцэхүйц баталгааг зарим улс нотариатын тухай хуулиараа зохицуулж, үйлчлүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлөх эрх зүйн хамгаалалтыг бий болгосон байна⁸¹.

⁷⁸ Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм. МХХ-ны Анхдугаар их хурлын тогтоол. 2013. Дугаар 9.

⁷⁹ Нотариатчийн ёс зүйн дүрэм. ХЗДХСайдын тушаал. 2019.. Дугаар А/219.

⁸⁰ Монголын Нотариатчдын танхимын Бүх гишүүдийн хурлын тогтоол. 2021.. Дугаар 08

⁸¹ Ч.Баянжаргал(2021). Нотариатын эрх зүйн зарим асуудал, харьцуулсан судалгаа (Хууль зүйн докторын зэрэг гориосон бүтээл). Уб.. 142 дахь тал.



Хууль зүйн хариуцлагын тогтолцоонд сахилга, ёс зүйн хариуцлага, Үндсэн хуулийн хариуцлага, захиргаа, иргэн, эрүүгийн гэх мэт нийгмийн харилцаа өргөжихийн хэрээр хариуцлага хүлээлгэх салбар, хариуцлагын төрөл нэмэгдэж байгаа болно.

Нотариатын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д заасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдсан Сахилгын зөвлөл нь тус хуулийн 54 дүгээр зүйлд заасан сахилгын шийтгэлийн сануулах шийтгэлийг оногдуулж, харин нотариатын үйл ажиллагаа эрхлэхийг 1 жил хүртэл хугацаагаар түр зогсоох, нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн оногдуулна гэж хуульчилсан байна.

Хүснэгт 8. Нотариатчид сахилгын шийтгэл оногдуулсан байдал⁸² (2020-2024)

он	Сануулан	1 жил хүртэл хугацаагаар түр зогсоосон	Зөвшөөрлийг хүчингүй болгосон	Нийт
2020	7	2	0	9
2021	4	1	1	6
2022	3	3	0	6
2023	9	1	5	15
2024	5	0	0	5
Нийт	28	7	6	41

Дээрх судалгаанаас харахад сүүлийн 5 жил 28 нотариатчид сануулах, 7 нотариатчийн нотариатын үйл ажиллагаа эрхлэхийг түр хугацаагаар зогсоосон, 6 нотариатчийн нотариатын үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгож, нийт 41 нотариатчид сахилгын шийтгэл оногдуулжээ. Нийт сахилгын шийтгэл оногдуулсан нотариатчийн тоог идэвхтэй үйлдэл хийж буй нотариатчийн тоотой харьцуулахад өндөр дүнтэй байна.

Шигтгээ 8.

Сахилгын шийтгэлийн хуульд заасан төрлийн нэмэгдүүлэх шаардлагагүй бөгөөд манай нотариатчдын хувьд нотариатын үйл ажиллагаа эрхлэхийг 1 жил хүртэл хугацаагаар түр зогсоох шийтгэл нь хүнд шийтгэлд орж байгаа. Анх бид тус шийтгэлийг оногдуулахдаа хамгийн дээд талын хугацаагаар буюу 1 жилээр оногдуулж байсан практик бий. Угтаа бол нотариатч нь төрийн хуулиар харьяалуулсан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ ажлын байр түрээс, өөрийнхөө болон туслахдаа цалинжуулах гэх мэт санхүүгээ өөрөө удирддаг тул бид өмнөх практикаа судлан дүгнэлт хийж, тухайн шийтгэлийг оногдуулахдаа богино хугацаагаар оногдуулах санал хүргүүлдэг болсон. Тус шийтгэлийн хувьд бол үр нөлөөтэй байх тул өөр шийтгэлийн олон сонголт нэмэгдүүлэх шаардлагагүй гэж үзэж байна.

Сахилгын зөвлөлийн гишүүнтэй
хийсэн ярилцлагын хэргээс

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль (2012)-ийг баталснаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй хуульчийн сахилга, ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хороо хүлээн авч, бүртгэлжүүлэн эрхэлж буй ажил албан тушаалын харьяаллаар нь холбогдох сахилга, ёс зүйн хороо зөвлөлд шилжүүлэн шийдвэрлүүлж байсан бөгөөд 2015-2020 онд өмгөөлөгчтэй холбоотой өргөдөл гомдлыг

⁸² Монголын Нотариатчдын танхимаас ирүүлсэн мэдээлэл, 2024.

шалган шийдвэрлэж, 63 өмгөөлөгчид хариуцлага хүлээлгэсэн байна⁸³. Өмгөөллийн тухай хууль батлагдсанаар Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд ирүүлсэн өмгөөлөгчтэй холбоотой өргөдөл, гомдлыг Өмгөөллийн мэргэжлийн хариуцлагын хороонд шилжүүлж, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох зохицуулалтыг хүчингүй болсонд тооцсон.

Өмгөөллийн тухайн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т Хууль, ёс зүйн дүрмийг зөрчсөн өмгөөлөгчид 1/сануулах, 2/өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нэгээс гурван жил хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх, 3/өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгох, мөн зүйлийн 31.8-д Өмгөөлөгч ёс зүйн зөрчил гаргаснаас хойш гурван жилийн хугацаа өнгөрсөн бол хариуцлага хүлээлгэхгүй гэж хуульчилсан байна.

Шүүхийн сахилгын хороо нь Шүүхийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д Шүүгчид оногдуулах сахилгын шийтгэлийг 1/хаалттай сануулах, 2/ нээлттэй сануулах, 3/цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, 4/шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах, 5/огцруулах гэж хуульчилсан. Мөн зүйлийн 56.2-т Энэ хуулийн 56.1.5-д зааснаас бусад шийтгэл оногдуулах сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш нэг жил, зөрчил гаргаснаас хойш хоёр жил өнгөрсөн бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулж болохгүй. 56.3-т Энэ хуулийн 56.1.5-д заасан шийтгэл оногдуулах сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш хоёр жил, зөрчил гаргаснаас хойш таван жил өнгөрсөн бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулж болохгүй гэж тус тус эрх зүйн байдлыг нь дордуулахгүйгээр хуульчилсан байна.

Прокурорын ёс зүйн зөвлөл нь Прокурорын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д заасан Прокурор хууль, байгууллагын дотоод журам, прокурорын мэргэжил, ёс зүйн дүрэм зөрчсөн, эсхүл хуульд заасан албан үүргээ биелүүлээгүй бол тухайн зөрчлийн шинж байдлыг харгалзан 1/ сануулах, 2/албан тушаалын цалингийн хэмжээг зургаан сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, 3/ зэрэг дэв бууруулах⁸⁴, 4/албан тушаал бууруулах⁸⁵, 5/ ажлаас халах шийтгэл оногдуулна. Мөн зүйлийн 67.2-т Мэргэжлийн алдаа, ёс зүйн зөрчлөөс бусад үндэслэлээр аймаг, нийслэл, дүүрэг, сум буюу сум дунд, дагнасан прокурорын газрын ерөнхий прокурор энэ хуулийн 67.1.1 (сануулах), 67.1.2 (албан тушаалын цалингийн хэмжээг зургаан сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах)-т заасан сахилгын шийтгэлийг харьяа прокурорт оногдуулдаг байна. Прокурорын ёс зүйн зөрчилд сахилгын шийтгэл оногдуулах хугацааг хуульчлаагүй бөгөөд энэхүү хугацааг тодорхой тусгах шаардлага тухайн байгууллагын хувьд үүсэх боломжтой юм.

Хүснэгт 9. Сахилгын шийтгэлийн төрөл (нотариат, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хуульч, албан тушаалтан)

Нотариатч	Өмгөөлөгч	Прокурор	Шүүгч
1. сануулах 2. нотариатын үйл ажиллагаа эрхлэхийг 1 жил хүртэл хугацаагаар түр зогсоох, 3. нотариатын үйл ажиллагаа эрхлэх	1. сануулах, 2. өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нэгээс гурван жил хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх,	1. сануулах, 2. албан тушаалын цалингийн хэмжээг зургаан сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, 3. зэрэг дэв бууруулах,	1. хаалттай сануулах, 2. нээлттэй сануулах, 3. цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, 4. шүүгчийн бүрэн эрхийг гурван сар

⁸³ Хуульчийн ёс зүйн зөрчил, шийдвэрлэлтэд хийсэн дүн шинжилгээ, Судалгааны тайлан, 2018.,

⁸⁴ Прокурорын тухай хууль (2017)-ийн 54 дүгээр зүйл.

⁸⁵ Прокурорын тухай хууль (2017)-ийн 44 дүгээр зүйл.

зөвшөөрлийг хүчингүй болгох	3. омгооллын үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгох	4. албан тушаал бууруулах 5. ажлаас халах	хүртэл хугацаагаар түлгэвүүлж, сургалтад суухыг даалгах. 5. огцруулах
-----------------------------	--	--	--

Нотариатчийн хийсэн үйлдэлд сахилгын шийтгэл оногдуулах хугацааг Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалын төсөлд нотариатчийн зүгээс ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргах, нотариатын үйлдэл нь шүүхээс хүчингүйд тооцогдож иргэн, хуулийн этгээд хохирох тохиолдол цөөнгүй гарч байна. Тухайлбал, 2015-2017 онд нотариатчийн гэрчилсэн үйлдлийг хүчингүй болгуулах талаарх 21 нэхэмжлэлийг шүүх хянан шийдвэрлэсэн бөгөөд шүүхийн шийдвэрээр нотариатын үйлдлийг хүчингүй болгож шийдвэрлэсэн тохиолдол 40 орчим хувийг эзэлж байх боловч энэ талаар тусгай зөвшөөрөл олгож байгаа байгууллага болон Нотариатчдын танхим тодорхой арга хэмжээ аваагүй байна. Мөн 2016 онд нотариатчийн үйлдэлтэй холбоотой 30 өргөдөл, гомдол Хууль зүй, дотоод хэргийн яам, Нотариатчдын танхимын дэргэдэх Сахилгын зөвлөл, бусад хууль хяналтын байгууллагад иргэдээс ирсэн бөгөөд ихэнх тохиолдлыг зөрчил гаргаснаас хойш хөөн хэлэлцэх хугацаа /1 жил/ өнгөрсөн гэсэн үндэслэлээр гомдлыг буцааж байгаа зэргээс үндэслэн нотариатчдаас түгээмэл гаргаж буй зөрчилд дүн шинжилгээ хийж, алдаа гаргасан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаарх журам, хүлээх хариуцлагыг тодорхой болгон, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх талаарх зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай байна.⁸⁶ гэснийг үндэслэн Нотариатын тухай хуулийн 51¹ дүгээр зүйлийн 51^{1.1}-д Нотариатчийн хийсэн үйлдэлд сахилгын шийтгэл оногдуулах хугацаа нь Иргэний хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааны дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 2 жил байна гэж нэмсэн. Энэхүү хугацааны хувьд 1/ өв залгамжлал, холбогдох баримт бичиг (өв хүлээн авах, өвлөхөөс татгалзах хүсэлт, тодорхойлолт, иргэний баримт бичгийн хуулбар, бүртгэлийн хуудас болон бусад) 60 жил, 2/өвлөх эрхийн гэрчилгээ, бүртгэлийн хуудас 60 жил, 3/ гэрээслэл, бүртгэлийн хуудас 60 жил, 4/ гэрээ, бүртгэлийн хуудас (өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн, бусад) 15 жил, 5/ итгэмжлэл, бүртгэлийн хуудас 10 жил, 6/ гарын үсгийн баталгаа, бүртгэлийн хуудас 10 жил, 7/үл хөдлөх эд хөрөнгө, бүртгэлийн хуудас, холбогдох баримт бичиг 15 жил, 8/хуулбарын бүртгэл 15 жил⁸⁷ гэж архивт хадгалах хугацааг заасан.

Тухайлбал, Иргэний хуулийн 528 дугаар зүйлийн 528.1-д Өвлүүлэгчийг нас барах хүртэл түүнтэй хамт амьдарч байсан өвлөгч нь өв нээгдсэнээс хойш гурван сарын дотор өв хүлээн авахаас татгалзсан тухайгаа нотариат буюу нотариат байхгүй газар баг, сумын Засаг даргад мэдэгдээгүй бол уг өвийг хүлээн авсан гэж үзнэ. 528.2 Энэ хуулийн 528.1-д зааснаас бусад өвлөгчид нь өв нээгдсэнээс хойш нэг жилийн дотор хуульд заасны дагуу өвлөгдсөн эд хөрөнгийг эзэмдэн авсан буюу эрхлэн удирдсан, эсхүл нотариат буюу баг, сумын Засаг даргад өв хүлээн авах буюу өвлөх эрхийн гэрчилгээ олгохыг хүсэж, өргөдөл гаргасан байвал уг өвийг хүлээн авсан гэж үзнэ. мөн хуулийн 531 дүгээр зүйлийн 531.1-д Хууль ёсны буюу гэрээслэлээр өвлөгч нь өвлөх эрхийн гэрчилгээ олгох хүсэлтийг өв нээгдсэн газрын нотариат, нотариатгүй газар баг, сумын Засаг даргад гаргана. Мөн хуулийн 537 дугаар зүйлийн 537.1-д Өв нээгдсэн газрын нотариат, нотариатгүй газар баг, сумын Засаг дарга шаардлагатай гэж үзвэл өвлөгч, өвлүүлэгчийн үүрэг гүйцэтгүүлэгч, түүнчлэн төрийн ашиг сонирхлын үүднээс өвлөгдөх эд

⁸⁶ Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал 2018.

⁸⁷ Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт, Архивын ерөнхий газрын даргын тушаал, 2023 он., Дугаар А/91. Хавсралт I.

хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авна гэж зохицуулжээ. Нотариатын тухай хуульд зааснаар нотариатч, нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэж байгаа албан тушаалтанд нотариатчийн эрх, үүрэг, холбогдох бусад зүйл, заалт нэгэн адил хамаарна гэсэн. Энэхүү зохицуулалт нь нотариатчийн хийсэн үйлдлийн буюу иргэний эрх зүйн үр дагавар бүхий хуульд заасан үйлчилгээг үзүүлсэн нь сахилгын шийтгэл оногдуулах хөөн хэлэлцэх хугацааг тоолохдоо иргэний эрх зүй дэх хөөн хэлэлцэх ерөнхий хугацаагаар тооцох салбар эрх зүйн харилцаанд үл хамаарахаар байна. Учир нь энэ төрлийн нотариатын үйлдлийг хийж буй нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэж байгаа албан тушаалтанд ч энэ хөөн хэлэлцэх хугацааг хамааруулах боломжтой юм.

Иргэний хууль бол иргэний харилцааны явцад учирсан хохирлыг нь арилгахыг гол зорилгоо болгодог бөгөөд ямар нэг цээрлүүлэх шинжийг огт агуулдаггүй.⁸⁸

Тус хөөн хэлэлцэх хугацааг хуульчилсантай холбоотойгоор баталсан “Нотариатын үйлдлийг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрийг хүргүүлэх журам”⁸⁹-д нотариатын үйлдлийг хүчингүй болгосон эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг хүлээн авч, нотариатч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон, иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг хүлээн авч нотариатын үйл ажиллагаанд хориглосон хэм хэмжээг зөрчсөн бол Сахилгын зөвлөлөөс Хууль зүй, дотоод хэргийн сайдад нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг хүргүүлэхээр журамласан байна.

Хүснэгт 10. Сахилгын шийтгэл оногдуулах хөөн хэлэлцэх хугацаа

Нотариат	Өмгөөлөл	Прокурор	Шүүх
Иргэний хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааны дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 2 жил байна.	ёс зүйн зорчил гаргаснаас хойш 3 жилийн хугацаа өнгөрсөн бол харилцааг хүлээлгэхгүй	–	сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 2 жил, зорчил гаргаснаас хойш 5 жил өнгөрсөн бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулж болохгүй

Дээрх хүснэгтээс харахад сахилгын шийтгэл оногдуулах хөөн хэлэлцэх дундаж хугацаа 3 жил байна.

Шигтгээ 9.

Нотариатчид сахилгын шийтгэл оногдуулах хугацаа нь Иргэний хуулийн 75.1-д заасан ерөнхий хугацаа 10 жилээр тооцох болсон. Энэхүү хугацаа нь бусад мэргэжлийн байгууллагын сахилга, ёс зүйн зорчилд шийтгэл оногдуулах хугацаанаас 3 дахин их хугацаатай байгааг эргэн харах шаардлагатай. Учир нь гэрээ, үл хөдлөх эд хоронго, бүртгэлийн хуудас, холбогдох баримт бичиг 15 жил, итгэмжлэл, гарын үсгийн баталгаа бүртгэлийн хуудас 10 жил, өв залгамжлал, өвлөх эрх, гэрээсэлэл 60 жилийн хугацаатайгаар архивт хадгалдаг. Эдгээр хугацаа нь хувийн эрх зүйн харилцаанд тоологддог бол сахилга, ёс зүйн зөрчлийн хувьд тус хугацааг харгалзан үзэх нь нотариатчийн эрх зүйн байдлыг дордуулсан зохицуулалт гэж харж байна.	Сахилгын зөвлөлийн гишүүнтэй хийсэн ярилцлагын хэсгээс
--	--

Иргэний хууль (2002)-ийн 1 дүгээр зүйлийн 1.1-д эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулахад оршино. Мөн зүйлийн 1.2-т Иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс

⁸⁸ Д.Зүмбэрэлхам (2022). Криминологийн онол. Уб., 12 дахь тал

⁸⁹ Нотариатын үйлдлийг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрийг хүргүүлэх журам, ХЗДХС-ийн, ШЕЗ-ийн даргын хамтарсан тушаал, 2020., Дугаар А/18. 12.

оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчимд үндэслэнэ гэж хуульчилсан бөгөөд сахилга, ёс зүйн зөрчлийн хувьд иргэний эрх зүйн харилцаанд хамаарахгүй тул тухайн хөөн хэлэлцэх хугацааг баримтлах нь учир дутагдалтай.

Зөвшөөрлийн тухай хууль (2022)-ийн 2.1 дүгээр зүйлийн 1.2, 8.2 дугаар зүйлийн 10-т зааснаар хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар эрхлэх үйл ажиллагааг энгийн зөвшөөрлөөр эрхлэх бөгөөд нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгохоор хуульчилсан. Тус зөвшөөрөл нь хуулиар энгийн зөвшөөрлийн төрөлд хамаарч байх тул мөн хуулийн 2.2 дугаар зүйлийн 3-т зааснаар нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаагүй олгодог байна.

Нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь нийтийн эрх зүйн харилцаанд хамаарч байх тул нотариатчийн ёс зүйн зөрчилд шийтгэл оногдуулах хөөн хэлэлцэх хугацааг шүүгч, өмгөөлөгч, төрийн жинхэнэ албан хаагчид сахилга, ёс зүйн шийтгэл оногдуулахад тоологдох хугацааг харгалзан үзэх зүйтэй.

Түүнчлэн эдгээр зөвлөл, хороод нь салбарынхаа хуульчид шийтгэл оногдуулсан талаар тус бүртээ хянан шийдвэрлэсэн маргааны сан бүрдүүлж, хариуцлага хүлээлгэсэн бүртгэлийг хөтөлж хэвшсэн бол Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдох бүртгэлийг Монголын Хуульчдын холбоонд нэгтгэн бүртгэлжүүлэх шаардлага үүсэж буйг тэмдэглэж байна.

2.8. Нотариатч эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаанд оролцож буй туршлага

Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль (2012)-ийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу тухайн салбарын эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулж болно” гэж заасан бол зүйлийн 8.2 дахь хэсэгт ийнхүү эвлэрүүлэн зуучлагчаар ажиллах этгээд нь дээд боловсролтой, эвлэрүүлэн зуучлагчийн сургалтад хамрагдан эрхийн гэрчилгээ авсан, тухайн чиглэлийн асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах эвлэрүүлэн зуучлагчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагч байх шаардлагыг тавьсан байна. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль хэрэгжиж эхэлснээр Шүүхийн ачаалал тодорхой хувиар буурсан амжилттай байгаа ч төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо үйл ажиллагааныхаа чиглэлээр эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулахад Эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангах нь тулгамдсан асуудал болжээ. Тухайлбал, Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан гэрээг тухайн шатны шүүгч баталгаажуулж, ИХШХШ тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2, 74.6 дахь хэсэг, 75 дугаар зүйлд заасны дагуу захирамж гаргаж, гүйцэтгэлийг хангуулдаг бол шүүхийн бус эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэгч биелүүлээгүй бол нөгөө тал нь ИХШХШ тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасны дагуу шүүхэд ханддаг байна. Иймд энэ төрлийн эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааг үр нөлөөтэй болгохын тулд дахин шүүхэд хандаж цаг хугацаа алдаж, чигрэгдэл үүсгэдэг байдлыг өөрчлөх шаардлагатай [Н.Норовсамбуу (2021) Эвлэрүүлэн зуучлалын онол, практик] гэжээ.

Хуулийн агуулга, хуулийн бүтэц, хэм хэмжээ, зохицуулах процесс, хууль хэрэгжүүлсэн үр дүн, ололт, сургамж

Манай улсын хувьд үндсэндээ шүүх дэх эвлэрүүлэн зуучлалыг эрх зүйн зохицуулалтдаа илүү тусгаж энэ чиглэлээр эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлсэн шинж ажиглагдаж байгаа бол эвлэрүүлэн зуучлалын олон жилийн түүхтэй Европ тивийн улсуудад шүүхээс эвлэрүүлэн зуучлалд хандахыг зөвлөх, эвлэрүүлэн зуучлагчийг сонгож өгөх зэрэг шүүхийн санаачилгад үндэслэсэн эвлэрүүлэн зуучлалын хэлбэр байдаг боловч үүний зэрэгцээ Франц зэрэг улс орнуудад ихэвчлэн маргаантай талуудын аль нэг нь эвлэрүүлэн зуучлагчийг сонгож, талууд бүгд хүлээн зөвшөөрснөөр эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа эхэлдэг зохицуулалт нийтлэг ажиглагдаж байна.

Иймд Монгол Улсад нотариатчийг эвлэрүүлэн зуучлагчаар ажиллуулах бол арбитрын жишгээр эвлэрүүлэн зуучлагчийг сонгох эрх зүйн зохицуулалтыг бий болгож эвлэрүүлэн зуучлагчаар олонд танигдсан нэр хүндтэй хүмүүс сонгогдон ажиллах үндэслэл, нөхцөлийг бүрдүүлэх шаардлага үүснэ гэж үзэж байна. Үүний зэрэгцээ зөвхөн хуульчид болон нотариатчийг бус эрүүл мэндийн, нийгмийн ажлын, үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын, бизнесийн болон худалдааны зэрэг бусад мэргэжлийн хүмүүсийг эвлэрүүлэн зуучлагчаар ажиллуулах асуудлыг эрх зүйн зохицуулалтыг өөрчлөхдөө нэгэн зэрэг шийдвэрлэж байж цогц бөгөөд үр дүнтэй өөрчлөлт болно гэж үзэж байна.

Ижил төсөөтэй улстай харьцуулсан үр дүн

Нотариатч бол өдөр бүр мэргэжлийнхээ үйл ажиллагаандаа үйлчлүүлэгчийг сонсдоогоороо гол үүрэг гүйцэтгэдэг. Нотариатч болон эвлэрүүлэн зуучлагчийн үүрэг бол юуны өмнө зөрчилдөөн үүсэхээс урьдчилан хариу зайлсхийх, урьдчилан сэргийлэх явдал⁹⁰ гэжээ.

Европын улс орнуудад эвлэрүүлэн зуучлал нь иргэнд илүү таатай арга зам гэж үзэж шүүхийн бус энэ арга замаар маргаан шийдвэрлэхийг дэмждэг бөгөөд иргэний болон арилжааны асуудлаарх эвлэрүүлэн зуучлалын зарим асуудлын тухай 2008/52/ЕС дугаар Удирдамжийг Европын зөвлөл болон Европын парламентаас 2008 онд баталж байжээ⁹¹.

Нотариатчдын эвлэрүүлэн зуучлалын чиг үүргийг гүйцэтгэж байсан нь олон жилийн түүхтэй⁹² бөгөөд Европын холбооны улсуудын хүрээнд хил дамнасан нотариатчийн эвлэрүүлэн зуучлалын тогтолцоог бий болгох асуудал 2016 оноос албан ёсоор хэлэлцэгдэж эхэлсэн нь цаашид улам хөгжиж 2018 онд “Эвлэрүүлэн зуучлал нотариатын төлөө – Нотариат эвлэрүүлэн зуучлалын төлөө” гэсэн төслийн анхны уулзалтыг Европын холбооны нотариатчдын байгууллага (CNUE)-аас Европын Комиссын Хууль зүй болон хэрэглэгчдийн асуудал эрхэлсэн Ерөнхий газар (DG JUST)-ын санхүүжилтээр зохион байгуулсан бөгөөд тус уулзалтаар “Эвлэрүүлэн зуучлал нотариатын төлөө – Нотариат эвлэрүүлэн зуучлалын төлөө” нэртэй хил дамнасан нотариатчийн эвлэрүүлэн зуучлалын практик заавар гаргасан байна. Энэхүү зааварт “... эвлэрүүлэн зуучлах үйл явц нь тухайн нөхцөл байдал тус бүрийн онцлог сэтгэл зүй, нийгмийн нарийн төвөгтэй байдлыг шийдвэрлэхэд чиглэсэн үндсэндээ нээлттэй ажиллагаа тул хэл, соёл, уламжлал, гарал үүсэл зэрэг асуудлаар үл ойлголцол үүсэхэд хил дамнасан эвлэрүүлэн зуучлалыг зохион байгуулах үндэслэл бүрдэх боломжтой” гэж дурдсан

⁹⁰ Марк Жирард (2022). Эвлэрүүлэн зуучлал нь маргаан шийдвэрлэх алтернатив арга болох нь. ОУЭШБХ-ын эмхтгэл, 51 дэх тал.

⁹¹ Notaries of Europe. Towards a common framework for notarial mediation in Europe. 2019, дэлгэрэнгүйг: <https://www.notariesofeurope.eu/en/notaries/mediation-notaries/>

⁹² European Commission For The Efficiency Of Justice (CEPEJ). Mediation Development Toolkit - Ensuring implementation of the CEPEJ Guidelines on mediation - Mediation Awareness and Training Programme for notaries. 2019, 2 дахь тал

байна⁹³. Үүнээс үзэхэд нотариатчдын эвлэрүүлэн зуучлалд гүйцэтгэх чиг үүрэг нь олон жилийн түүхтэй бөгөөд энэ үйл ажиллагаа улам хөгжиж хил дамнасан нотариатын эвлэрүүлэн зуучлалын бүтцийг бий болгох олон санаачилга хэрэгжиж эхлээд байна.

Шүүхийн үйл ажиллагааны үр дүнтэй байдлын Европын комисс (СЕРЕЈ)-ийн Шүүхийн тогтолцооны үнэлгээний ажлын хэсэг (СЕРЕЈ-GT-EVAL)-ээс 2018 оны нотариатчдын өгсөн мэдээллийн нэгтгэн боловсруулсан “СЕРЕЈ-ийн хуулийн салбарын мэргэжлийн талаарх тусгай судалгаа: Нотариатчид - 2018 оны мэдээлэл” нэртэй бүтээлд “... Итгэмжлэгдсэн гуравдагч этгээдийн хувьд нотариат нь маргааныг шүүхийн бус замаар шийдвэрлэхэд, зарим тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гишүүн орнуудад эвлэрүүлэн зуучлалын салбарт хэрэглэж буй шилдэг туршлага нь Бельги, Франц, Герман, Итали, Польш, Словени зэрэг улсад байгаа бөгөөд шүүхийн ачааллыг бууруулахад нотариатчийн мэргэжил чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг онцолж байна” гэж дурджээ⁹⁴. Эвлэрүүлэн зуучлал нотариатын төлөө – Нотариат эвлэрүүлэн зуучлалын төлөө” нэртэй хил дамнасан нотариатчийн эвлэрүүлэн зуучлалын практик зааварт дурдсанаар Герман Улсад нотариатч эвлэрүүлэн зуучлагчийн үйл ажиллагааг эрхлэх асуудлыг тодорхой хууль тогтоомжоор зохицуулсан зохицуулалт байхгүй боловч эвлэрлийн гэрээг нотариатаар батлах шаардлагыг хуульд заасан онцлогтой байна⁹⁵. Түүнчлэн Сингапур Улсын хууль тогтоомжид нотариатч нь эвлэрүүлэн зуучлагчаар давхар ажиллахыг хориглосон эсхүл зөвшөөрсөн тодорхой зохицуулалт байхгүй.

Франц Улсад нотариатчийн эвлэрүүлэн зуучлах төвүүд ажилладаг бөгөөд Францын нотариатчид ажлын байрныхаа хүлээлгийн танхимд нотариатчийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, нотариатын эвлэрүүлэн зуучлалын төвүүдийн талаар иргэдэд сурталчлах зурагт хуудас байрлуулж сурталчилгааны ажлыг явуулдаг байна⁹⁶. Тус улсад нотариатчид эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа явуулахдаа эвлэрүүлэн зуучлалын сургалтад заавал хамрагдсан байх ёстой⁹⁷ бөгөөд гэр бүл, үл хөдлөх хөрөнгө, компанийн болон бизнесийн эрх зүйн асуудлаар эвлэрүүлэн зуучлал явуулдаг байна⁹⁸. Тус улсад нотариатч нь хүндтэй мэргэжилд тооцогдох бөгөөд энэ талаар “Францын нотариатчид төрийн албан тушаалд ажиллаж буй бусад хүнтэй ижил тэнцүү, эсхүл өндөр нэр хүндтэй байр суурийг эзэлдэг” гэж 1911 онд судлаач В.В.Смитерс бичжээ⁹⁹. Ийнхүү нэр төртэй, бие даан ажилладаг нийтийн албан хаагчийн үүрэг гүйцэтгэдэг нотариатчийг иргэд эвлэрүүлэн зуучлагчаар сонгох магадлал өндөр. Мөн тус улсад шүүх нь маргагч талуудад эвлэрүүлэн зуучлагчдын жагсаалтаас зуучлагчийг сонгож

⁹³ Мөн тэнд, 9 дэх тал

⁹⁴ CEPEJ-GT-EVAL, Specific Study of the CEPEJ on the Legal Professions: Notaries – 2018 data, 2021 он, 13 дахь тал, дэлгэрэнгүйг: <https://rm.coe.int/cepej-report-data-2018-cnue/1680a4d1ec>

⁹⁵ European Commission For The Efficiency Of Justice (CEPEJ), Mediation Development Toolkit - Ensuring implementation of the CEPEJ Guidelines on mediation - Mediation Awareness and Training Programme for notaries, 2019, 33-р тал

⁹⁶ CEPEJ-GT-EVAL, Specific Study of the CEPEJ on the Legal Professions: Notaries – 2018 data, 2021 он, 12 дахь тал, дэлгэрэнгүйг: <https://rm.coe.int/cepej-report-data-2018-cnue/1680a4d1ec>

⁹⁷ Францын нотариатчдын танхимын албан ёсны вебсайт, Notarial mediation, 2022, дэлгэрэнгүйг үзэх холбоос: <https://www.notaires.fr/en/mediation>

⁹⁸ Францын нотариатчдын танхимын албан ёсны вебсайт, Mediation by notaries, an amicable alternative for resolving conflicts, дэлгэрэнгүйг үзэх холбоос: <https://mediation.notaires.fr/le-notaire-mediateur/#presentation>

⁹⁹ W. W. Smithers, History of the French Notarial System, 60 U. Pa. L. Rev. 19 (1911), Дэлгэрэнгүйг үзэх холбоос: https://scholarship.law.upenn.edu/penn_law_review/vol60/iss1/3

өгөх боломжтой боловч талууд өөрсдөө тохиролцон эвлэрүүлэн зуучлагчаа сонгох боломжтой ажээ¹⁰⁰.

Эстони Улсын 2010 оны Эвлэрүүлэн зуучлах тухай хуулийн 16 дугаар зүйлд нотариатчийн эвлэрүүлэн зуучлалын асуудлыг тусган зохицуулсан бөгөөд тус зүйлийн (1) дэх хэсэгт нотариатч нь Нотариатчдын Танхимд өргөдөл гарган эвлэрүүлэн зуучлагчаар ажиллах хүсэлтээ бүртгүүлэх бөгөөд эвлэрүүлэн зуучлагчаар ажиллах хүсэлтэй нотариатчдын талаарх мэдээллийг танхим нь салбарын сайдад хүргүүлэхээр заасан бөгөөд тус зүйлийн (2) дахь хэсэгт Нотариатчдын Танхим болон Хууль зүйн яам нь тухайн эвлэрүүлэн зуучлагчаар ажиллах нотариатчийн мэдээллийг нийтэд ил тод байршуулахаа зохицуулсан байна. Харин Эвлэрүүлэн зуучлах тухай хуулийн 3 дугаар зүйлийн (3) дахь хэсэгт "... эвлэрүүлэн зуучлагчийн үүрэг гүйцэтгэж байгаа нотариатч, тангараг өргөсөн өмгөөлөгч нь мэргэжлийн үйл ажиллагааг нь зохицуулсан хууль тогтоомжоор тогтоосон хараат бус, шударга байх шаардлагыг давхар дагаж мөрдөнө" гэж, тус хуулийн 18 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт "... Нотариатчийн гүйцэтгэх эвлэрүүлэн зуучлагчийн ажилд Нотариатын тухай хууль болон Нотариатын сахилгын шийтгэлийн тухай хуульд заасны дагуу ... салбар хариуцсан сайд хяналт тавина" гэж заажээ. Эстони Улсын нотариатын тухай хууль тогтоомжийн зохицуулалт нь Монгол Улсын хуультай харьцангуй ойролцоо бөгөөд нотариатчийн үйл ажиллагаанд хууль зүйн салбарын асуудал эрхэлсэн сайд хяналт тавьж, нотариатчийн болон эвлэрүүлэн зуучлагчдын бүртгэлийг Хууль зүйн яам нь хөтөлдөг байна. Харин манай улсад нотариатч нь эвлэрүүлэн зуучлагчаар ажиллах эрх зүйн үндэслэл одоогоор байхгүй. Харин Эстони Улсад шүүхийн даалгаснаар эсхүл маргааны талуудын аль нэгийн хүсэлтээр эвлэрүүлэх үйл ажиллагаа эхэлж болох бөгөөд хуульд эвлэрүүлэн зуучлагчийн ажиллах газар нутгийн хязгаар заагаагүй байна. Мөн Европын холбооны эрх зүйн зохицуулалтын дагуу Эстони Улсын эвлэрүүлэн зуучлагч нь хил дамнан ажиллах боломжтой бөгөөд нотариатч нь эвлэрүүлэн зуучлагчаар ажиллах тохиолдолд хуульд зааснаас бусад тохиолдолд манай улс шиг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамааран ажиллахгүй, уригчийн сонголтоор ажилладгаараа ялгаатай байна.

Эдгээрээс дүгнэвэл Европын улс орнуудад нотариатч нь эвлэрүүлэн зуучлагчийн үүрэг гүйцэтгэж ирсэн эртний түүхтэй бөгөөд нотариатч-эвлэрүүлэн зуучлагчийн үйл ажиллагааг хил дамнасан байдлаар гүйцэтгэх боломжийг судлан тухайн салбарыг улам бүр хөгжүүлж байна. Гэвч Герман зэрэг зарим улсад нотариатч нь эвлэрүүлэн зуучлагчийн чиг үүргийг давхар гүйцэтгэж болох зохицуулалт, туршлага байхгүй байна. Францад нотариатч нь нэр хүндтэй албан тушаал тул маргаантай талуудаас нотариатчийг эвлэрүүлэн зуучлагчаар сонгох магадлал өндөр боловч эвлэрүүлэн зуучлалын сургалтад заавал хамрагдах шаардлагатай. Эстони Улсад нотариатч нь өөрөө хүсэлт гаргасны үндсэн дээр аливаа шалгалтгүйгээр эвлэрүүлэн зуучлагчаар бүртгүүлэн ажиллах боломжтой байна. Манай улсын хувь нотариатч эвлэрүүлэн зуучлагчаар ажиллах эрх зүйн зохицуулалтыг шинээр батлан мөрдүүлэх тохиолдолд нотариатчийг сургалтад хамруулах болон сонгон шалгаруулах эсэх болон өөрийн нотариатын үйлдэл гүйцэтгэсэн асуудлаар эвлэрүүлэн зуучлал хийхгүй байх зэрэг салбар дундын ёс зүйн асуудлыг урьдчилан зохицуулах зэргийг нэмэлтээр зохицуулах шаардлага бий болно. Түүнчлэн нотариатын хэрэгцээ шаардлага ихтэй орон нутагт нотариатч нь эвлэрүүлэн зуучлал хийхээс татгалзах үндэслэл тусдаа байх эсэх асуудал мөн үүсэх боломжтой байна.

¹⁰⁰ Consulegis. Mediation in Focus: France, 2023. дэлгэрэнгүйг үзэх холбооц: <https://consulegis.com/insights/news-articles/359-mediation-in-focus-france>

Түүнчлэн нотариатчийн эвлэрүүлэн зуучлалын эрх зүйн зохицуулалтыг бусад мэргэжлийн этгээдүүдийн эвлэрүүлэн зуучлал явуулах эрх зүйн үндэслэлтэй хамт боловсруулж холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах байдлаар нэвтрүүлэх боломжтой юм.

Гурав. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1. Дүгнэлт

1. *Гэрчлэх чиг үүргийг хэрэгжүүлэгч субъектийн үйл ажиллагаа зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт тулгамдаж буй асуудал байгаа эсэх*

Нотариатын тухай хуульд заасны дагуу гэрчлэх чиг үүргийг хэрэгжүүлж буй субъектийн хувьд төрийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх ажлыг орон нутаг, хилийн чандад хэрэгжүүлж байна. Энэхүү судалгааны хугацаанд Нотариатын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан субъектийн тоог шинэчилсэн байдлаар гаргуулан авсан бөгөөд нийт 279 нотариатчийн үүрэг гүйцэтгэгч, эрх аваагүй орон гарсан 30 байна. Хилийн чанд (Элчин сайдын яам, Байнгын төлөөлөгчийн газар, Ерөнхий консулын газар, консул)-д 50 орчим нотариатчийн үүрэг хавсран гүйцэтгэгч ажиллахаар байгаа ч судалгааны хугацаанд тоон мэдээллийг бүрэн авч чадаагүй болно. Эдгээр субъектүүдээс гадна Иргэний хуулийн 523 дугаар зүйлийн 523.2 дахь хэсэгт эрх олгосон цэргийн ангийн удирдлага, хорих ангийн дарга, онгоцны ахмадын хувьд нотариатын үйлдэл хийх төрлөөс нэр зааж, гэрчилсэн тохиолдолд нотариатаар гэрчлүүлсний нэг адил үзнэ гэж хуульчилсан зэрэг нь мөн адил нотариатын үйлдэл гүйцэтгэж байгаа этгээд гэж үзэхээр байна. Нотариатын чиг үүргийг хавсран гүйцэтгэж буй эдгээр субъектийн нотариатын үйлдэл цахим санд бүрэн бүртгэгдэж байж энэ төрлийн төрийн үйлчилгээний чанар хүртээмж болон өнөөгийн нөхцөл байдалд цогц дүн шинжилгээ хийх нь зүйтэй байна. Нотариатчийн үүргийг хавсран хэрэгжүүлж буй субъектүүдэд нотариатын танхимаас арга зүйн болон мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж хэвшсэн нь сайшаалтай бөгөөд цаашид сургалт, мэдээллийн үйлчилгээнд бүрэн хамрагдаж буй явцтай хавсран гүйцэтгэж байгаа субъектын судалгааг холбон тогтмолжуулснаар салбарын нэгдсэн тоо, хөдөлгөөнийг хянах боломж бүрдэх юм.

Нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэгч ажиллуулж буй улсын туршлагад Франц, Герман, Сингапур, Эстони Улсын эрх зүйн зохицуулалтыг судлан үзсэн бөгөөд төрийн албан хаагч, нотариатчийн тодорхой чиг үүргийг манай улстай адилтгах хүрээнд хэрэгжүүлдэг. Үүнээс гадна Сингапур Улсын хэрэгжүүлж буй нотариатын үйлчилгээг хүртээмжтэй, хариуцлагатай хүргэх зорилго бүхий хуульчийн эрх бүхий этгээдтэй 12 хүртэлх сараар гэрээ байгуулан хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ нотариатын үйлдэл хийх зөвшөөрөл олгодог туршлагыг нэвтрүүлэх, ялангуяа хуульчаар гүйцэтгүүлэх боломжийг харгалзан үзэх нь зүйтэй юм.

2. *Нотариатын тойрог, тойрог шилжих зохицуулалт зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт тулгамдаж буй асуудал байгаа эсэх*

Нотариатын тойрог нэмэх, өөрчлөх талаарх саналыг Нотариатын танхимд хуулиар олгосон бөгөөд ийнхүү батлагдсан зарим тойрогт, ялангуяа алслагдсан орон нутагт нотариатын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилго, нотариатч үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжих боломж нь төдийлөн хангагдах боломжгүй байгаа нь нотариатч тойрог шилжих хүсэлт гаргах нэг үндэслэл болж байгаа гэж үзэж байна. Энэ асуудлыг

нотариатчдын төлдөг хураамжаас зарцуулан тэнцвэржүүлдэг Франц Улсын туршлагыг нэвтрүүлэх талаар судалж, шийдвэрлэх боломжтой байна.

Нотариатч тойрог шилжин ажиллах хүсэлтээ өгч мэргэшлийн шалгалт дахин өгөх зохицуулалтыг хуульчилснаар тойрог шилжих шалгалтыг 1 удаа зохион байгуулсан байна. Судалгааны явцад тойрог шилжих шалгалт өгч нөөцөд орсон нотариатчдаас сул орон тоо гарсан тойрогт томилгоо хийлгүй, үндсэн нөөцөөс томилгоо хийдэг гэсэн шүүмжлэл гарч байсныг дурдах нь зүйтэй. Тойрог шилжилтийг мэргэшлийн шалгалт дахин өгсөн үр дүнгээр эрэмбэлэн шилжүүлж буй өнөөгийн туршлага нь эерэг болон сөрөг талтай байна. Нотариатын үйл ажиллагаа эрхэлсэн орлогоос санхүүжин амьдрах болон бусад шалтгааны улмаас тухайн тойрогтоо ажиллах боломжгүй байгаа нотариатчдад мэргэшлийн ур чадвараараа өрсөлдөн шилжин ажиллах боломжийг нээж өгсөн нь эерэг байна. Харин нотариатчийн мэргэшлээрээ ажиллаж буй нотариатчийн тойрог шилжих шалгалтыг мэргэшсэн байдалд дүгнэлт өгч болохуйц, хэмжигдэхүйц агуулгаар боловсруулах шаардлагатай мөн тухайн тойрогт шилжин ажиллах хүсэлт өгсөн нотариатч мэргэшлийн шалгалт дахин өгсөн ч шалгалтын босго даваагүй бол тухайн нотариатчийг өмнө ажиллаж байсан тойрогт нь үргэлжлүүлэн ажиллуулахад бэрхшээл үүсч болохоор байна. Харьцуулсан судалгааны хүрээнд судалсан гадаадын улс орнуудад тойрог шилжих тохиолдолд шалгалт авдаггүй, зарим тохиолдолд харьяалах бүрэн эрхт этгээдийн зүгээс зөвшөөрөл олгосны дагуу нотариатч нь тойргоосоо гадуур үйл ажиллагаа явуулах боломжтой бөгөөд зайн гэрчлэл хийсэн үйлдлийг тойрогтоо хийсэнд тооцдог, нэг нотариатч тойрогтоо хэд хэдэн ажлын байртай байж болдог зэрэг онцлог ажиглагдаж байна.

3. Сахилгын зөвлөл болон Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүн, эрх хэмжээ, бүрэн эрхийн хугацааны талаарх зохицуулалт зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт тусламдаж буй асуудал байгаа эсэх;

Нотариатын танхимын дэргэдэх Сахилгын зөвлөлийн бүрэлдэхүүн хуулиар харьяалуулсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц, ажиллаж буй гишүүдийн бүрэн эрхийн хугацаа, үндсэн ажил эрхлэлт, гишүүнд тавих урьдчилсан шаардлага зэргийг харьцуулсан судалсан болно.

Сахилгын зөвлөлийн бүрэн эрхийн хугацааг Нотариатын тухай хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төсөл Хууль зүйн байнгын хороонд хэлэлцэх үед 4 жил байхаар оруулсан хэдий ч дэмжигдэлгүй, хугацааг шинэчлэн оруулалгүй орхигдуулсны улмаас 2019 онд байгуулагдсан Сахилгын зөвлөл өөрчлөгдөх боломжгүйгээр ажиллаж байна. Сахилгын зөвлөлийг шүүх, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл тус бүр хоёр, Танхимаас гурав, нийт долоон гишүүн бүхий холимог бүрэлдэхүүнтэй байгуулахаар хуульчилсан нь өмнө хийгдсэн хуулийн хэрэгжилтийн судалгаанд хөндсөн асуудалд эерэг өөрчлөлт авчирсан зохицуулалт болсон. Гэвч Сахилгын хорооны бүрэлдэхүүнд Улсын дээд шүүхийн шүүгчид ажиллаж байгаа нь Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 50.1.16-д шүүгч нь багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсрахыг хориглохоор заасанд нийцэхгүй, мөн шүүхийн өмнөх шатанд буюу урьдчилан шийдвэрлэх процесст шүүгч оролцож байгаа нь тухайн асуудлыг шүүхээр шийдвэрлэх, ялангуяа Улсын дээд шүүхийн шүүгчийн оролцож шийдвэрлэсэн сахилгын шийтгэлтэй холбоотой асуудлыг давж заалдах шатны шүүхийн шүүгч хянаж шийдвэрлэх нь

зарим талаар хууль хэрэглээнд үл ойлголцол үүсэж болзошгүй тул Сахилгын хороонд шүүгчийг ажиллуулах шаардлагагүй.

Мэргэшлийн хорооны хувьд бүрэн эрхийн хугацаа, чиг үүрэг нь хорооны гишүүдийн тоотой харьцуулахад хүрэлцэхүйц харин гишүүдийн эрхэлж буй ажил, албан тушаалыг нэр заасан бүрэлдэхүүнтэй байх нь тохиромжгүй гэж үзэж байна. Иймд харьцуулан судалсан хууль зүйн салбарын мэргэжлийн байгууллагуудын ижил чиг үүрэг бүхий мэргэшлийн болон сахилга, ёс зүйн зөвлөл, хорооны бүрэлдэхүүнд шүүгчийг албан тушаалаар нь оруулсан нийтлэг зохицуулалт байгаа нь тухайн шүүгчийг албан тушаалынх нь хувьд бүрэлдэхүүнд оруулснаар шүүгчид аливаа нөлөөлөл, эрсдэл үүсэх эсэх талаар нарийвчлан судлаагүй байдал ажиглагдсан болно. Шүүгч зөвлөл, хорооны бүрэлдэхүүнд орсноор процессын ажиллагаа нь чанаржиж буй сайн тал ажиглагдсан ч шүүгчид ямар шалгуураар зөвлөл, хороонд орж буй нь тодорхойгүй, тухайн шүүхэд ирүүлсэн албан бичиг болон хуульд тус бүрэлдэхүүнд шүүгч ажиллана гэсэн ерөнхий зохицуулалтын дагуу танхимын тэргүүн аль нэг шүүгчид санал болгож буй жишиг байна.

Шүүгч аль нэг зөвлөл, хорооны бүрэлдэхүүнд орохдоо шүүх таслах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхгүй хэдий ч аливаа гомдол, мэдээллийг шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа болно. Энэ нь шүүх, шүүгчид салбарын болон бусад хуулиар үүрэг хүлээлгэсэн зохицуулалтыг нэмэгдүүлэх тал ажиглагдах болсныг тэмдэглэж байна. Тухайлбал, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль (2024)-ийн 6-9 дүгээр зүйлд Улсын дээд шүүхэд Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх тухай заасан нь бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлж буй чиг үүргийг хуулиар шүүхэд шилжүүлсэн энэ нь Үндсэн хуульд заасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд нөлөөлж буй нэг хэлбэр гэж үзэж болох юм. Иймд хууль зүйн салбарын мэргэжлийн байгууллагын аливаа зөвлөл, хороод шүүгч гишүүнтэй байна гэсэн зохицуулалтыг эргэн харах, шүүгч зөвхөн хуульчийнхаа хувьд Монголын Хуульчдын холбооны аливаа үйл ажиллагаанд оролцох мөн хуульч профессорынхоо хувьд ажиллах боломжтойг тэмдэглэж, шүүгч гишүүнтэй байх гэсэн Нотариатын зөвлөл, хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах нь зүйтэй. Энд дурдсан агуулга нь Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны шүүгч гишүүн ажиллах зохицуулалтаас өөр агуулгатай болохыг тэмдэглэж байна.

4. Цахим зайн гэрчлэлт хийх хэрэгцээ, шаардлага, практикт тулгамдаж буй асуудал байгаа эсэх:

Нотариатын байгууллага нотариатын үйл ажиллагааг цахимжуулах байдлаар зарим үйлчилгээг хүртээмжтэй болгож, ажиллаж байгаа нь сайшаалтай.

Харин судалгааны хүрээнд цахим болон зайны гэрчлэлт гэсэн 2 тусдаа үйлчилгээг хэрхэн зааглах, зайнаас гэрчлэх үйлчилгээг нэвтрүүлэх дэд бүтэц, хүний нөөцийн боломжийг харгалзан судалсан болно.

Сонгон судалсан гадаадын зарим улсын зайны гэрчлэлтийн үйлчилгээг нэвтрүүлсэн туршлагаас үзэхэд Франц, Герман, Эстони, Сингапур Улсын танин баталгаажуулах сүүлийн үеийн найдвартай, технологи, өндөр хурдны интернэтийн дэд бүтцийг ашиглан төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд зайны нотариатын үйлчилгээг нэвтрүүлсэн байна.

Монгол Улсын хувьд зайн гэрчлэлт хийх нийгмийн шаардлага үүссэн, эрх зүйн зохицуулалтууд бүрдсэн боловч цаашид интернэтийн өндөр хурдтай холболт, сүүлийн

үеийн технологи, өндөр хурдны интернэтийн дэд бүтцийг бий болгоход анхаарал хандуулах шаардлагатай. Зайн гэрчлэлтийг нэвтрүүлснээр Монгол Улсын Иргэний хуульд заасан цахим хэлбэрээр хэлцэл хийх хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх, мэргэжлийн бус этгээд нотариатын үйлчилгээ үзүүлэхийг хязгаарлах, нотариатын үйлчилгээ иргэнд хүртээмжтэй ойртох үндсэн боломж үүсэх давуу талтай.

5. Нотариатын мэдэгдэх хуудас зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт тулгамдаж буй асуудал байгаа эсэх;

Нотариатын мэдэгдэх хуудас нь нотариатын үйлдлийн төрөлд орсноос хойш тус үйлчилгээний хууль зүйн үр дагавар, ач холбогдлыг хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх хүрээнд оновчтой хэлбэрээр танилцуулалгүй ирснийг сүүлийн 4 жилд Нотариатын мэдэгдэх хуудас бичсэн тоон үзүүлэлтээс дүгнэж болох юм. Тухайлбал, 2021 онд 32, 2022 онд 72, 2023 онд 213, 2024 онд 155 нотариатын мэдэгдэх хуудас бичжээ.

МХХ-ны Нотариатчдын хөгжлийг дэмжих хорооноос санаачлан холбогдох байгууллагуудтай хамтран “Нотариатын мэдэгдэх хуудас шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл болох нь” сэдэвт хэлэлцүүлгийг 2023 онд зохион байгуулж, Монголын Нотариатчдын танхим, Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандсан санал, зөвлөмжийг гаргасан, улмаар нотариатын мэдэгдэх хуудас бичсэн тоо өмнөх оныхтой нь харьцуулахад 3 дахин нэмэгдсэн дүнтэй байгаагаас харахад тус үйлчилгээний шүүхийн ачаалал бууруулах ач холбогдлыг өргөжүүлэн нотариат болон шүүхийн ерөнхий зөвлөлийн статистик, мэдээ тайланд нотариатын мэдэгдэх хуудас бичиж ирүүлсэн тоо, баталгаажуулсан тоо, баталгаажуулахаас татгалзсан үндэслэл зэргийг тусгайлан гаргаж, нотариатчийн мэргэшлийн сургалтыг тухайн сэдвийн хүрээнд үе шаттай зохион байгуулах, нотариатын танхим олон нийтэд чиглэсэн хууль зүйн мэдээллийг тогтмол хүргэх зэрэг ажлыг хэрэгжүүлснээр мэдэгдэх хуудас бичих тоо нэмэгдэж, хууль зүйн ач холбогдол өргөжих боломжтой байна.

6. Нотариатчид сахилгын шийтгэл оногдуулах хугацаа, сахилгын шийтгэлийн төрөл зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт тулгамдаж буй асуудал байгаа эсэх.

Нотариатчид сахилгын шийтгэл оногдуулах хөөн хэлэлцэх хугацааг Иргэний эрх зүй дэх хөөн хэлэлцэх ерөнхий хугацаагаар тооцох хууль зүйн зохицуулалтыг оруулж ирснээр нотариатчийн ёс зүй, сахилга хариуцлага дээшилсэн эсэх талаарх дүгнэлтийг өгөх боломжгүй бөгөөд нотариатчийн үйлдэл хийхтэй холбогдсон тухайн хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхтэй холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан “Нотариатын үйлдлийг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрийг хүргүүлэх журам”-ыг баталсан байна. Тус журмын зохицуулалтаар шүүхээс нотариатын үйлдлийг хүчингүй болгосон шийдвэр гаргасан тохиолдолд Сахилгын хороо нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлэн шийдвэрлүүлэхээр зохицуулсан байна. Тус журмыг хэрэгжүүлэх явцад дээр дурдсан хөөн хэлэлцэх хугацаатай холбогдсон шийдвэр гарсан эсэхийг тусгайлан Нотариатын үйлдлийг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж дүгнэх нь зүйтэй.

Мөн нотариатчийн үүрэг хавсран гүйцэтгэж буй субъект нь нотариатчийн нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээх хуулийн зохицуулалттай. Хэрэв үүрэг хавсран гүйцэтгэгчийн

үйлдлийг хүчингүй болгох тохиолдолд хэрхэн хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй байх тул цахим нотариатын үйл ажиллагаанд бүх үүрэг гүйцэтгэгчийг нэгтгэх, үйлдлийг бүрэн цахимжуулах шаардлагатай.

Нотариатчид хүлээлгэх сахилгын шийтгэлийн төрөл нь өнөөгийн нөхцөлд тохиромжтой гэсэн дүгнэлт өгч байгаа бөгөөд сахилгын шийтгэл оногдуулах хөөн хэлэлцэх хугацааг зөрчлийн бус хэрэг, маргааны хөөн хэлэлцэх хугацаагаар тоолж байгааг өөрчлөх шаардлагатай. Нотариатын үйлдлийг хүчингүй болгосон шүүхийн шийдвэртэй тохиолдолд шүүхийн журмаар хохирол, гэм хорыг барагдуулах хуулийн зохицуулалттайг дурдах нь зүйтэй.

7. Нотариатч эвлэрүүлэн зуучлагчаар ажиллах боломж, бусад улсын туршилага

Манай улсад нотариатч нь эвлэрүүлэн зуучлагчаар ажиллах эрх зүйн үндэслэл бүрдээгүй бөгөөд хэрэв ийм эрх зүйн зохицуулалт шинээр нэмж оруулах бол арбитрын жишгээр эвлэрүүлэн зуучлагчийг сонгодог эрх зүйн зохицуулалтыг бий болгож нотариатч-эвлэрүүлэн зуучлагчаар ажиллах эрх зүйн үндсийг хуульчлах, түүнчлэн салбар дундын ёс зүйн асуудлыг урьдчилан зохицуулах, нотариатч-эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэн зуучлах ажиллагаанаас татгалзах тусгай үндэслэлийг тусгах зэрэг нэмэлт зохицуулалт шаардлагатай юм.

Эдгээрээс гадна нотариатчийн эвлэрүүлэн зуучлалын эрх зүйн зохицуулалтыг бусад мэргэжлийн этгээдийн эвлэрүүлэн зуучлал явуулах эрх зүйн үндэслэлтэй хамт боловсруулж холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах байдлаар нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

3.2. Зөвлөмж

1. Нотариатчийн мэргэшлийн хорооны ажиллах журмын 4 дүгээр зүйлийн 4.14-т Нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, нотариатын тойрог шилжихтэй холбогдсон шалгалтад тэнцсэн иргэний шалгалтын дүн 3 жилийн хугацаанд хүчинтэй байх бөгөөд уг хугацаанд тухайн тойрогтоо нөөцөд байна гэж журамласан нь Нотариатын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т заасан Нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулсан мэргэшлийн шалгалтад тэнцсэн тохиолдолд олгоно, гэсэн зохицуулалтыг өргөжүүлсэн. Мөн тус хэрэгжилтийн үнэлгээнд авагдсан чанарын судалгаанд дурдсан тойрог шилжих мэргэшлийн шалгалт дахин өгсөн нотариатчийн эрх зүйн байдлыг дордуулсан агуулгатай гэсэн шүүмжлэлийг дагуулж байх тул эдгээр нөөц бүрдүүлэн ажиллаж буй журмыг хуульд нийцүүлэх өөрчлөх;
2. Нотариатын танхимын дэргэдэх Сахилгын зөвлөлийг Монголын Хуульчдын холбооноос 2 хуульч профессорыг¹⁰¹, Монголын Өмгөөлөгчдийн холбооноос 2 өмгөөлөгч, Нотариатын танхимаас 3 нотариатч гэх мэт 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, бүрэн эрхийн хугацааг нэг удаа 4 жил байхаар хуульчлах;
3. Мэргэшлийн хороог нотариатын төлөөлөл 5, Монголын Хуульчдын холбооноос 2 хуульч профессор гэж 7 хүний бүрэлдэхүүнийг шинэчлэх;

¹⁰¹ Нотариатын танхим хуульч профессоруудыг сахилга, ёс зүйн болон мэргэшлийн зөвлөл, хорооны бүрэлдэхүүнд оруулах зөвлөмжийг хэрэгжүүлэх тохиолдолд урьдчилсан шалгуур тавьж, нэр дэвшүүлэх боломжтой зохицуулалтыг тусгах нь зүйтэй.

4. Нотариатчийн ёс зүйн зөрчилд сахилгын шийтгэл оногдуулах хөөн хэлэлцэх хугацааг ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 1 жил, зөрчил гаргаснаас хойш 2 жилийн хугацаа өнгөрсөн бол ёс зүйн хариуцлага хүлээлгэхгүй гэж хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулах;
5. Зайн гэрчлэлтийн эрх зүйн зохицуулалтыг бий болгосноор тухайн үйлчилгээг найдвартай эрсдэлгүй хүргэх техник, технологийн боломж, интернэтийн тасалдалгүй хүртээмжтэй байдлыг шийдвэрлэх зэрэг дагалдах хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай.

-oOo-

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх эх сурвалж

Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг

1. Үндсэн хууль, 1992 он
2. Нотариатын тухай хууль, 2011 он
3. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, 2012 он
4. Шүүхийн тухай хууль, 2021 он
5. Прокурорын тухай хууль, 2017
6. Иргэний хууль, 2002 он
7. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он
8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017 он
9. Зөвшөөрлийн тухай хууль, 2022 он
10. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, 2021 он
11. Шүүхийн захиргааны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль, 2021 он
12. Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 10 дугаар зарлигийн Хавсралт II.
13. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын Хавсралт I
14. Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүдийг томилох тухай. УИХ-ын 2021 оны 92 дугаар тогтоол.
15. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын Хавсралт I
16. Нотариатын үйлдлийг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрийг хүргүүлэх журам, ХЗДХСайд, ШЕЗ-ийн даргын хамтарсан 2020 оны А/18, 12 дугаар тушаал
17. Нотариатын тойрог, нотариатын тоог тогтоох тухай. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/10, А/136, А/198 дугаар тушаал
18. Нотариатын тойрог шилжих журам, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/38 дугаар тушаалын хавсралт
19. Монголын Нотариатчдын танхимын дэргэдэх "Сахилгын зөвлөлийн ажиллах журам", Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/77 дугаар тушаалын хавсралт
20. Нотариатчийн мэргэшлийн хорооны ажиллах журам. Хууль зүйн сайдын 2016 оны А/06 дугаар тушаалын Хавсралт I.
21. Нотариатын тойрог шилжих журам. Хууль зүйн сайдын 2021 оны А/38 дугаар тушаалын хавсралт
22. Нотариатын цахим мэдээллийн санд мэдээллийг хүлээн авах, хадгалах, ашиглах, түүний аюулгүй байдлыг хангах журам. Хууль зүйн сайдын 2020 оны Дугаар А/01 дүгээр тушаалын хавсралт
23. Нотариатын үйлдэл хийх заавар. Хууль зүйн сайдын 2011 оны Дугаар 171 дүгээр тушаалын Хавсралт IV.
24. Нотариатын үйлдэл хийх заавар. ХЗДХСайдын 2021 оны А/210 дугаар тушаалын хавсралт (өөрчилсөн).
25. Нотариатын үйлчилгээний хөлс, зардал. Хууль зүйн сайдын 2011 оны 123 дугаар тушаалын хавсралт
26. Нотариатын үйлдлийг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрийг хүргүүлэх журам, ХЗДХСайд, ШЕЗ-ийн даргын хамтарсан тушаал, 2020., Дугаар А/18, 12.
27. Монголын Нотариатчдын танхимын дүрэм, Монголын Нотариатчдын танхимын бүх гишүүдийн хурлын 2011 оны 07 дугаар тогтоол
28. Монголын Нотариатчдын танхимын Бүх гишүүдийн хурлын 2021 оны 08 дугаар тогтоол

29. Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны Дугаар 110 дугаар тогтоолын хавсралт
30. Прокурорын ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай. Монгол Улсын ерөнхий прокурорын 2021 оны А/18 дугаар тушаалын хавсралт
31. МӨХ-ийн Мэргэшлийн хорооны ажиллах журам
32. Өмгөөлөгчийн шалгалт зохион байгуулах журам. МӨХ-ны Удирдах зөвлөлийн 2021 оны 49 дүгээр тогтоолын хавсралт
33. МӨХ-ны Мэргэшлийн хорооны ажиллах журам. МӨХ-ны Удирдах зөвлөлийн 2021 оны 14 дүгээр тогтоолын Хавсралт I.
34. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм. МХХ-ны Анхдугаар их хурлын 2013 оны 9 дүгээр тогтоол
35. Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт. Архивийн ерөнхий газрын даргын тушаал. 2023 оны А/91 дүгээр тушаалын Хавсралт I.
36. Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал 2018 он

Ном сурах бичиг, ном

1. Д.Зүмбэрэлхам, Криминологийн онол.Уб., 2022
2. Монгол Улсын шүүхийн сахилгын хороо (түүхэн хөгжил). Уб., 2023

Нэг сэдэвт бүтээл

1. Ч.Баянжаргал. Нотариатын эрх зүйн зарим асуудал, харьцуулсан судалгаа (Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл). Уб., 2021

Судалгааны тайлан, эмхтгэл

1. Нотариатын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ. Судалгааны тайлан. Уб., 2018
2. Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх, эвлэрүүлэн зуучлал ба нотариат ОУЭШБХ-ын эмхтгэл. Уб., 2022.9.13.
3. Прокурорын хараат бус байдал: прокурорын байгууллагын тогтолцоо, удирдлага, өөрөө удирдах байгууллага. Эрүүгийн эрх зүйд холбогдох судалгааны тайлангийн эмхтгэл. Уб., 2024
4. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. Уб., 2020
5. Нээлттэй нийгэм форум. Эрдэм сургалт судалгааны хүрээлэн. Боловсролын салбарт коронавируст цар тахлын үзүүлж буй нөлөөлөл цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүртээмж, үр дүн, нөлөөлөгч хүчин зүйлс, 2020.
6. Хуульчийн ёс зүйн зөрчил, шийдвэрлэлтэд хийсэн дүн шинжилгээ. Судалгааны тайлан. 2018.

Бусад

1. Монголын Нотариатчдын танхимын 2023, 2024 оны тайлан
2. Нотариатын мэдэгдэх хуудас бичих, баталгаажуулахтай холбоотой санал, зөвлөмж. МХХ-ны Ерөнхийлөгчийн албан бичиг. 2024.1.18-ны өдөр.
3. Ч.Баянжаргал (2024). Гэрээний биелэлтийг хялбараар шийдвэрлэх нь..

Гадаад хэл дээр

Эх сурвалж

1. Notarycam, The Difference Between Electronic Notarization, Remote Notary, and Mobile Notary, 2023.
2. Notaries of Europe, Towards a common framework for notarial mediation in Europe, 2019.

3. European Commission For The Efficiency Of Justice (CEPEJ), Mediation Development Toolkit - Ensuring implementation of the CEPEJ Guidelines on mediation - Mediation Awareness and Training Programme for notaries, 2019
4. CEPEJ-GT-EVAL, Specific Study of the CEPEJ on the Legal Professions: Notaries – 2018 data, 2021

Цахим холбоос

1. https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070633/LEGISCTA00006164545/#LEGISCTA000006164545
2. <https://sso.agc.gov.sg/SL/322-R3>
3. https://www.gesetze-im-internet.de/englisch_bnoto/englisch_bnoto.html
4. <https://adrianleeds.com/subscribe-to-our-publications/french-property-insider/fpi-archives/notaires-in>
5. <https://e-estonia.com/estoniadigital-enlightenment/>
6. https://www.gesetze-im-internet.de/englisch_bnoto/englisch_bnoto.html
7. <https://www.notarvcam.com/difference-between-electronic-notarization-remote-notary-and-mobile-notary/>
8. <https://www.notaires.fr/en/notarial-profession/role-notaries-and-his-principal-activities/power-attorney-notary-how-sign-online>
9. <https://www.riioiteataja.ee/en/eli/530102013080/consolide>
10. <https://online.notar.de/en/help-faq/general-information/official-portal-for-online-notary-appointments>
11. <https://www.imda.gov.sg/how-we-can-help/10g-nbn-grant>
12. <https://www.imda.gov.sg/resources/press-releases-factsheets-and-speeches/press-releases/2024/announcement-of-e-apostille-and-gpt-legal>
13. <https://www.notaires.fr/en/mediation>
14. https://scholarship.law.upenn.edu/penn_law_review/vol60/iss1/3
15. <https://consulegis.com/insights/news-articles/359-meditation-in-focus-france>
16. <https://ikon.mn/n/33s3>
17. <https://e-mongolia.mn/services/citizen/sector/646597f28c629b783b14fdf6>
18. <https://www.consul.mn/services>